Co-funded by the European Union

switchasia PROGRAMME

FONDATION Abbé Pierre

CZECH REPUBLIC DEVELOPMENT COOPERATION

COAП SWITCH OFF AIR POLLUTION

БАРИЛГЫН САЛБАРЫН БИЧИЛ, ЖИЖИГ, ДУНД АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГА, БРИГАДУУУДЫН МЭДЭЭЛЛИЙН САНГ БҮРДҮҮЛЭХ

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ
2019 ОН

geres ACTING FOR CLIMATE SOLIDARITY

PEOPLE IN NEED CZECH REPUBLIC

Монголын Барилгын Үндэсний Ассоциаци

GER COMMUNITY MAPPING CENTER

BEEC БАРИЛГЫН ЭРЧИМ ХҮЧ ХЭМНЭЛТИЙН ТӨВ BUILDING ENERGY EFFICIENCY CENTER

БАРИЛГЫН САЛБАРЫН БИЧИЛ, ЖИЖИГ, ДУНД АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГА, БРИГАДУУУДЫН МЭДЭЭЛЛИЙН САНГ БҮРДҮҮЛЭХ

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

ЗАХИАЛАГЧ: “МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ” ТББ

ГҮЙЦЭТГЭГЧ: “НОГООН САНААЧЛАГА-ИРЭЭДҮЙН ТЕХНОЛОГИ” ТББ

BY NC ND

УЛААНБААТАР ХОТ
2019 ОН

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ 4
ХҮСНЭГТ, ЗУРГИЙН ЖАГСААЛТ 5
ӨМНӨТГӨЛ 7
СУДАЛГААНЫ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА 8
1.1. Судалгааны зорилго, зорилт 10
1.2. Судалгааны бэрхшээл 11
1.3. Судалгааны түүвэрлэлт, хамрах хүрээ 12
1.4. Туслах судлаачдыг бэлтгэх сургалтын үйл ажиллагаа 13
1.5. Судалгааны асуулга, ярилцлагын хуудасны бүтэц 13
1.6. Туршилтын судалгаа, түүний зохион байгуулалт 14
1.6.1. Судалгааны мэдээлэл цуглуулах ажлын зохион байгуулалт 15
1.6.2. Судалгааны мэдээлэл боловсруулалт 16
БҮЛЭГ 2. СУДАЛГААНД ХАМРАГДСАН БЖДҮЭ-ИЙН (бригадуудын) СУДАЛГААНЫ ҮР ДҮН 18
БҮЛЭГ 3. СУДАЛГААНД ХАМРАГДСАН БАРИЛГЫН САЛБАРТ АЖИЛЛАХ СОНИРХОЛ БҮХИЙ ИРГЭДИЙН СУДАЛГААНЫ ҮР ДҮН 35
Амьдарч байгаа орон сууцны төрлөөр нь авч үзвэл 226 нь буюу 34 % нь гэрт, 204 (30.7 %) нь байшинд, 177 (26.6 %) нь орон сууцанд, 29 (4.4 %) хувь нь нийтийн байранд, 23 (3.5 %) нь тохилог сууцанд амьдардаг байна (Зураг 31). 38
БҮЛЭГ 6. МОНГОЛ УЛСАД ХЭРЭГЖСЭН ИЖИЛ ТӨСТЭЙ ТӨСЛИЙН СУРГАМЖ, ЖИШЭЭ 65
ДҮГНЭЛТ, САНАЛ ЗӨВЛӨМЖ 72

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
БСШУСЯ	Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яам
БЖДҮЭ	Бичил, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч
МБҮА	Монголын Барилгын Үндэсний Ассоциаци
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ҮСХ	Үндэсний Статистикийн Хороо
ТББ	Төрийн бус байгууллага

ХҮСНЭГТ, ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 3. Бригадын жилийн орлого, аж ахуйн хэлбэрээр 25
Хүснэгт 4. Бригадын жилийн орлого, гишүүдийн тоогоор 26
Хүснэгт 5. Барилгын ажлын үнэлгээ, 2018.12.26-ны байдлаар 27
Хүснэгт 6. http://brigad.mn/ сайтанд бүртгэлтэй бригадуудын статистик үзүүлэлт 31
Хүснэгт 7. Ам бүлийн тоо, насны ангиллаар 40
Хүснэгт 8. Өрхийн орлого, боловсролын түвшингээр 41
Хүснэгт 9. Эмэгтэйчүүдтэй ажиллах давуу болон сул тал 45
Хүснэгт 10. Сургалтанд хамрагдах боломжтой саруул, хувиар 50
Хүснэгт 11. Сургалт авах боломжтой өдөр 51

Зураг 1. Бригадууд цайны цагаар судалгаа өгч буй байдал 11
Зураг 2. Бригадын гишүүд судалгаа өгч буй байдал 12
Зураг 3. Судлаачдад судалгааны арга зүйн сургалт өгч буй байдал 13
Зураг 4. Судлаачдад арга зүйн сургалт, туршилт судалгаа 14
Зураг 5. Батлагдсан асуулгын дагуу судалгаа авч буй нь 15
Зураг 6. Судалгааны явц 15
Зураг 7. Мэдээллийн санг бэлдэх явц, судлаач-операторуудад зааварчилгаа өгч буй нь 16
Зураг 8. Мэдээллийн санг нэгтгэх, хянах явц 17
Зураг 9. Бригадуудын үйл ажиллагаа явуулж буй байршил, дүүргээр 19
Зураг 10. Байшингийн дулаан алдагдлын төрлүүд 20
Зураг 11. Бригадуудын үйл ажиллагааны чиглэл 21
Зураг 12. Бригадуудын барилгын салбарт ажилласан туршлага, жилээр 22
Зураг 13. Судалгаанд оролцогч бригадууд 23
Зураг 14. Судалгаа авах үеийн бригадын үндсэн гишүүдийн тоо 23
Зураг 15. Бригадын үйл ажиллагаа идэвхтэй явагддаг сар 24
Зураг 16. Бригадуудын жилийн нийт орлого 24
Зураг 17. Ажилтай үеийн нэг гишүүний нэг өдөрт олж буй орлого дунджаар 25
Зураг 18. Бригадын гишүүдийн харъяалал 26
Зураг 19. Бригадын гишүүдийн амьдарч буй сууцны төрөл 28
Зураг 20. Сүүлийн 3 жилийн хугацаанд ажлынхаа хөлсийг авч чадаагүй тохиолдол 29
Зураг 21. Бригадуудад тохиолддог бэрхшээл 30
Зураг 22. Бригадуудын ажлын захиалгаа олдог хэлбэр 30
Зураг 23. Brigad.mn сайт 31
Зураг 24. Бригадуудад шаардлагатай байгаа сургалтын төрөл 32
Зураг 25. Бригадуудын ахлагч нарын төслийн талаарх санал 33
Зураг 26. Судалгаанд хамрагдсан иргэдийн харъяалал 36
Зураг 27. Судалгаанд оролцсон иргэдийн хүйсийн харьцаа 36
Зураг 28. Төсөлд хамрагдах сонирхолтой иргэдийн хүйсийн харьцаа 37
Зураг 29. Судалгаанд оролцогчдын насны ангилал 37
Зураг 30. Судалгааны оролцогчдын ам бүлийн тоо 37
Зураг 31. Амьдарч байгаа орон сууцны төрөл 38
Зураг 32. Сууцны эзэмшлийн хэлбэр 38

Зураг 33. Судалгаанд оролцогчдын орон сууцны эзэмшлийн хэлбэр 39
Зураг 34. Судалгаанд оролцогчдын гэр бүлийн байдал 39
Зураг 35. Судалгаанд оролцогчдын боловсролын түвшин 40
Зураг 36. Өрхийн дундаж орлого 41
Зураг 37. Судалгаанд оролцогчдын сүүлийн 3 жилийн хугацаанд ажиллаж байсан газар 42
Зураг 38. Судалгаанд оролцогчдын ажил олж авдаг сувгууд 43
Зураг 39. Сүүлийн 3 жил ажлаа сольсон байдал 43
Зураг 40. Ажлаа тогтвортой хийж байгаа шалтгаан 44
Зураг 41. Ажлаа тогтворгүй хийж байгаа шалтгаан 44
Зураг 42. Барилгын салбарт хийж гүйцэтгэж байсан ажил 45
Зураг 43. Ажил хийхэд чухал нөхцөл 46
Зураг 44. Барилгын дулаалгын чиглэлээр мэргэших сонирхол 46
Зураг 45. Дулаалгын чиглэлээр сурч цаашид хийх ажлын сонирхол 47
Зураг 46. Байшин дулаалах ажил цаашид тогтмол хийх хандлага 47
Зураг 47. Зээл авах шаардлага тулгарсан үед ханддаг газар 48
Зураг 48. Зээл авахад тохиолддог хүндрэлүүд 49
Зураг 49. Судалгаанд оролцогчдын сургалтанд хамрагдаж байсан байдал 49
Зураг 50. Шаардлагатай байгаа сургалтын хэрэгцээ 50
Зураг 51. Хөдөөнөөс хот руу ирж ажиллахад тулгардаг бэрхшээл 51
Зураг 52. Шалгуур үзүүлэлт 1-ийг хангасан бригадуудын ерөнхий үзүүлэлт 52
Зураг 53. Шалгуур үзүүлэлт 2-ийг хангасан бригадуудын ерөнхий үзүүлэлт 53
Зураг 54. Шалгуур үзүүлэлт 2-ийг хангасан бригадуудын ерөнхий үзүүлэлт /үргэлжлэл/ 54
Зураг 55. Барилгын салбарт ажиллах сонирхол бүхий иргэний 1-р шатны сонгон шалгаруулалт, нэгдүгээр шалгуураар 55
Зураг 56. Нэгдүгээр шатны сонгон шалгаруулалт, хоёрдугаар шалгуураар 56
Зураг 57. Нэгдүгээр шатны сонгон шалгаруулалт, гуравдугаар шалгуураар 57
Зураг 58. Нэгдүгээр шатны сонгон шалгаруулалт, гуравдугаар шалгуураар 58
Зураг 59. Нэгдүгээр шатны сонгон шалгаруулалт, дөрөвдүгээр шалгуураар 59
Зураг 60. Нэгдүгээр шатны сонгон шалгаруулалт, тавдугаар шалгуураар 60
Зураг 63. Нэгдүгээр шатны сонгон шалгаруулалт, долоодугаар шалгуураар 61
Зураг 64. Нэгдүгээр шатны сонгон шалгаруулалт, наймдугаар шалгуураар 62
Зураг 65. Нэгдүгээр шатны сонгон шалгаруулалт, есдүгээр шалгуураар 63
Зураг 67. Нэгдүгээр шатанд тэнцсэн иргэдийн үзүүлэлт, 10 дахь шалгуураар 64
Зураг 70. Дулаалгын аян төсөлд оролцогчдын үндсэн үүрэг 65
Зураг 71. Дулаалга аяныг хэрэгжүүлэх алхмууд 66
Зураг 72. Дулаалгын аянаас айлд тавигдах шалгуур үзүүлэлт 66
Зураг 73. Дулаалгын аяны ТУН-ийн хяналтын программын хэсэг 67
Зураг 74. Өрхийн байшинг дулаалах процесс 68
Зураг 75. Дулаалгын аянд ашиглагдсан дулаалгын материалууд 70
Зураг 76. Дулаалгын аянд оролцогч өрхийн ханын дулаалгын материалын сонголт 71

ӨМНӨТГӨЛ

2016 оны статистик мэдээгээр Нийслэлийн гэр хорооолд 88,000 гэр сууц, 106,000 орчим байшин сууц, 1,800 гаруй тохилог амины сууц бүртгэгдэн халаалтанд жилд дунджаар 700 мянга гаруй тонн нүүрс хэрэглэдэг нь тогтоогдсон байна. Улаанбаатар хотод суурьшихаар нүүж ирсэн хувь хүн, айл өрх өөрийн өмчилсөн эсвэл хамаатан садныхаа эзэмшиж байгаа хувийн өмчийн зориулалттай газар буюу хашаанд амьдардаг. Хөдөө, орон нутгаас шилжин суурьшигсад амьдарч буй газар/хашаандаа төрөл бүрийн материал, загвар хийцтэй амины сууцыг хөрөнгө санхүүгийнхээ боломжид тааруулан барьдаг. Гэвч эдгээр амины сууц нь дулааны алдагдал ихтэй, технологийн алдаатай баригддаг тул хүйтний улиралд айл өрхийн нүүрсний хэрэглээ өндөр, улмаар нүүрсний утаанаас үүдэлтэй агаарын бохирдлыг нэмэгдүүлж байна.

Гэр хорооллын амины сууцны дулааны алдагдлыг шийдэж буй арга зам нь өртөг зардлын хувьд олон янз байна. Тэр дундаа эрчим хүчний хэмнэлттэй аргаар байр сууцаа дулаалах нь эдийн засгийн хувьд хэмнэлттэй байгаад зогсохгүй агаарын бохирдлыг бууруулахад ач холбогдолтой юм.

Францын ЖЭРЭС (Сэргээгдэх эрчим хүч, байгаль орчны эв нэгдлийн групп) ТББ нь Монголын Барилгын Үндэсний Ассоциаци (МБҮА) ТББ, Барилгын эрчим хүч хэмнэлтийн төв, Пипл ин нийд, Гэр иргэдийн оролцоотой амьдрах орчны зураглалын төв ТББ-тай хамтран 2018-2022 онуудад Европын Холбооны санхүүжилттэй “Улаанбаатар хотын гэр хорооолд дулааны алдагдал багатай байшин барихад дэмжлэг үзүүлж, зөвлөгөө өгөх, санхүүгийн зуучлалын үйлчилгээ үзүүлэх” төслийг хэрэгжүүлж эхлээд байна.

2017 оны байдлаар Улаанбаатар хотын гэр хорооолд 1600,00 айл өрхийн амины сууцны дулаан алдагдлыг бууруулах шаардлагатай байгаа бөгөөд түүнээс 1,000 айл өрхөд нь эрчим хүчний хэмнэлттэй, дулааны алдагдлыг бууруулсан шийдлүүдийг санал болгон засвар, үйлчилгээг хэрэгжүүлэх нь тус төслийн зорилго юм.

Энэхүү төслийн хүрээнд МБҮА-ийн захиалгаар “Ногоон Санаачлага - Ирээдүйн Технологи” ТББ нь гэр хорооллын амины сууцны дулаан алдагдлыг бууруулахад чиглэсэн бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчид болон бригад, хувь хүний мэдээллийн санг бүрдүүлэх, дүн шинжилгээг хийх судалгааг гүйцэтгэлээ.

Судалгааны ажлыг удирдаж явуулахад арга зүйн болон техникийн зөвлөгөө өгч хамтран ажилласан ажилтнуудад талархал илэрхийлье. Мөн мэдээлэл цуглуулах үйл ажиллагаанд хамтран ажилласан бидний судалгаанд үнэт мэдээлэл өгсөн ААНБ-ын ажилтнуудад талархлаа илэрхийлье.

ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГУУЛЛАГА:

Судалгаа, шинжилгээний “Ногоон санаачлага - Ирээдүйн технологи” ТББ

ЗАХИАЛАГЧ:

ЖЭРЭС Монгол ТББ,

Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ

geres ACTING FOR CLIMATE SOLIDARITY
PEOPLE IN NEED CZECH REPUBLIC
Монголын Барилгын Үндэсний Ассоциаци
GER COMMUNITY MAPPING CENTER
BEEC БАРИЛГЫН ЭРЧИМ ХҮЧ ХЭМНЭЛТИЙН ТӨВ BUILDING ENERGY EFFICIENCY CENTER

СУДАЛГААНЫ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Улаанбаатар хотын төвийн 6 дүүргийн хэмжээнд барилгын салбарт үйл ажиллагаа явуулж буй “Бичил, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч буюу бригадууд” (цаашид БЖДҮЭ буюу бригад гэх)-ын ажлын туршлага, мэргэжлийн чадавхи, эдийн засгийн үзүүлэлт, ажиллах хүчний мэдээллийг багтаасан мэдээллийн санг бүрдүүлэх, мэдээллийн санд дүн шинжилгээ хийх судалгааны ажил нь тус төслийн зорилгод нийцэх үзүүлэлт бүхий 50 бригад, барилгын салбарт ажиллах сонирхол бүхий иргэнийг нэг, хоёрдугаар шатны сонгон шалгаруулалтаар үйл ажиллагааг зохион байгуулж тодорхойлох зорилготойгоор хийгдэж байна.

Энэхүү судалгааны эхлэл болгож туршилт судалгаа зохион байгуулсан ба Улаанбаатар хотын 6 дүүрэгт идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй барилгын ажил гүйцэтгэж буй бригад, иргэнийг хамруулаа.

Барилгын салбарт үйл ажиллагаа явуулж буй бригадын нөөц, чадавхи сонирхлыг тодорхойлохдоо бригад болон байгууллага, нэгжийн талаарх мэдээлэл, бидний санал тавьж буй ажилд оролцох сонирхол, хэрвээ тухайн бригад гэр хорооллын байшинг дулаалах ажлыг сонирхож буй бол уг ажилд хэдэн хүнтэй, хэчнээн бригадыг санал болгох боломж, ажиллах хүчнээ хэрхэн бүрдүүлдэг, бригадын тогтвортой байдлыг хэрхэн хангадаг талаар ярилцлага авах замаар судалгааны мэдээллийн санг бүрдүүллээ. Нийт 43 асуулт бүхий судалгааны анкетаар судалгааг авч нэгтгэлээ.

Мөн барилгын салбарт ажиллаж буй иргэдээс ерөнхий мэдээлэл, ажлын туршлага, ур чадвар, оролцогчийн сонирхол, сургалт, санхүүгийн хэрэгцээ зэрэг 4 бүлэг асуулгаар 43 асуулт бүхий судалгааг авч үр дүнг нэгтгэн гүйцэтгэсэн.

1990-ээд оныг хүртэл барилгын мэргэжилтэй ажилчид аль нэг барилгын байгууллагад харъяалагддаг, тухайн байгууллага нь ажилчдаа мэргэжлийн чиглэлээс нь шалтгаалан бригадуудад хуваарилан, нэгдсэн зохион байгуулалттайгаар тасралтгүй сурч хөгжих, нийгэмших боломжтой ажилладаг байсан. Тухайн ажилчдын нийгмийн халамжийн асуудал ч мөн энэ л тогтолцоогоороо дамжин хэрэгжсээр ирсэн. Харин өнөөдөр барилгачид тодорхой харъяалалгүй, чөлөөт бригадууд дор нэгдэж ажиллаж байна. Өрлөг, мужаан, дотоод засал, цахилгаан, сантехник, гагнуур, шавар, карказ угсралт, гадна фасад, арматур, дээвэр, чулуу плитаны зэрэг 12 төрлийн бригадууд бий болсон. Судалгааны явцад бригадууд нь хөрөнгө оруулагч, захиалагч, гүйцэтгэгч байгууллагатай гэрээтэй, гэрээгүй ажилладаг хэдий ч ажил дуусаны дараа хөдөлмөрийн хөлсөө цаг хугацаанд нь эсвэл бүр авч чадахгүй хохирох нь элбэг байна. Нийт судалгаанд оролцогчдын 89 хувь нь сүүлийн 3 жилийн хугацаанд ажлынхаа хөлсийг авч чадаагүй 3 хүртэл тохиолдол байна гэж илэрхийлжээ. Энэ нь нэг талаас бригадуудын эрх зүйн чадамж сул, нөгөө талаас захиалагчтайгаа ажлын чанар үр дүнг өөрсдийн чадвар чадамжид суурилан зөв хүлээлт бүхий үр дүнг үзүүлж чадахгүй байгаатай холбоотой юм.

Түүнчлэн бригадууд татвар, даатгал төлдөггүй нь энэ судалгаанаас харагдаж байна. Тэр ч бүү хэл барилгын ажил гүйцэтгэхдээ гадаад иргэний, компанийнн, бригадын, хувь хүний гэсэн 4 төрлийн үнэ тариф мөрдөж байна. Үүний ялгаа зааг нь тухайн ажлын гүйцэтгэлийн чанар стандартаас гадна, татвар төлөх эсэхтэй ч холбоотой юм.

Судалгаанд оролцсон бригадуудын үйл ажиллагааны чиглэл, төрөл, үйл ажиллагаа явуулж буй дүүрэг, ажилласан жил зэрэг үзүүлэлтүүд харьцангуй жигд тархалттай байна.

Бригадуудын үндсэн гишүүдийн тоо ихэвчлэн 3-6 хүн байх бөгөөд туслах гишүүнийг шаардлагатай үед нэмэх замаар бригад бүрдүүлж ажиллаж байна. Бригадууд 3-12 сард илүү ачаалалтай ажилладаг бол судалгаанд оролцогчдын 23 хувь нь жилийн дөрвөн улиралд үйл ажиллагаа явуулдаг байна.

Судалгаанд хамрагдсан бригадуудын 70 хувь нь жилийн 30 сая хүртэл төгрөгийн орлоготой ажилладаг байна. Энэ нь бид судалгаандаа бичил, жижиг гүйцэтгэгч нарыг тодорхойлох төслийн зорилготой нягт холбоотой юм. Өөрөөр хэлбэл, томоохон гүйцэтгэгч нараас зайлсхийх, тэдгээрт гэрээгээр ажиллаж буй бригадуудыг оролцуулах зорилго тавьсантай ч холбоотой юм.

Харин бригадуудын олж буй орлого нь тэдгээрийн статус буюу ХХК, барилгын зөвшөөрөлтэй ХХК, зөвшөөрөлгүй бригад эсэхээс хамаарахгүй байна. Мөн бригадуудын орлого түүний гишүүдийн тоо, их бага байхаас ч хамаарахгүй байна. Энэ нь тэдгээрийн танил тал, өмнөх захиалагчаасаа ажлаа олж гүйцэтгэдэгтэй холбоотой юм.

Бригадын гишүүдийн 48 хувь нь хөдөө орон нутгийн иргэд байна. Бригадын гишүүдийн нийгмийн байдлыг судалж үзвэл 37 хувь нь гэрт, 38 хувь нь гэр хорооллын байшинд амьдардаг байна.

Мөн эдгээр бригадууд санхүүгийн, хүний нөөцийн хомсдол, найдвартай гэрээгээр ажиллах зэрэг асуудлыг тулгамдаж буй хамгийн гол бэрхшээл хэмээн тодорхойлсон байна. Ийм бригадуудын нийгмийн асуудал, тэдгээрийн сургах, хөгжүүлэх асуудал, эрх зүйн мэдлэг чадвартай болгох аливаа ажлаа чанар стандартыг баримталж ажиллах, бизнесийн зарчмаар хийж гүйцэтгэх, гүйцэтгүүлж сурах хандлага ихээхэн чухал юм.

Бригадуудын дээрх үр дүнгээс гадна гэр хорооллын байшинг дулаалах чадвар бүхий 96 бригад, 97 иргэнийг тодорхой арга зүйн дор тодорхойлж нэгдүгээр шатны сонгон шалгаруулалтаар тодорхойллоо. Тэдгээрийг дараагийн шатны ярилцлагад урих, ярилцах замаар 2-р шатны сонгон шалгаруулалтад 33 бригад, 19 иргэнийг сонгон шалгаруулж тодорхойллоо.

БҮЛЭГ 1. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

1.1. Судалгааны зорилго, зорилт

Улаанбаатар хотын төвийн 6 дүүргийн хэмжээнд барилгын салбарт үйл ажиллагаа явуулж буй "Бичил, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч буюу бригадууд" (цаашид БЖДҮЭ буюу бригад гэх)-ын ажлын туршлага, мэргэжлийн чадавхи, эдийн засгийн үзүүлэлт, ажиллах хүчний мэдээллийг багтаасан мэдээллийн санг бүрдүүлэх, мэдээллийн санд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр төслийн зорилгод нийцэх үзүүлэлт бүхий 50 БЖДҮЭ-ийг сонгон шалгаруулах **үйл ажиллагааг зохион байгуулахад судалгааны ажлын зорилго оршино**.

Нэгдүгээр зорилт: Судалгаанд хамрагдсан ББЖДҮ-ийн ерөнхий мэдээлэл тэр дундаа ажиллах хүчний мэдээлэл, мэргэшсэн байдал, эдийн засгийн үзүүлэлт, ажлын туршлагыг багтаасан мэдээллийн санг үүсгэх. Мэдээллийн санг бүрдүүлэх судалгааны хүрээнд боловсруулсан санал асуулгын анкетыг БЖДҮЭ дээр туршиж шалгаж, хөгжүүлнэ. Үүнд:

1.1. Барилгын салбарт үйл ажиллагаа явуулж буй БЖДҮЭ-ийн мэдээллийн сангийн бүтцийг тодорхойлох
1.2. Судалгаанд хамрагдах байгууллагын мэдээллийг цуглуулах асуулгыг боловсруулах, туршилт тест хийж сайжруулах.
1.3. Судалгаа хийх арга зүйг тодорхойлж, судалгаа хийх хүн хүч, ашиглагдах бусад нөөцийг бүрдүүлэх
1.4. Судлаачдад зааварчилга өгөх, мэдээллээр хангах. Судалгааны нарийвчилсан төлөвлөгөөг гаргах, судалгааг хийх, хянах, зөвлөх.
1.5. Судалгааны анкетыг мэдээллийг мэдээллийн санд оруулах.
1.6. Судалгааны мэдээллийн санг бүрдүүлсэн үйл явцыг тайлагнах.

Хоёрдугаар зорилт: Судалгааны хүрээнд үүсгэсэн мэдээллийн сан дээр дүн шинжилгээ хийсний дараа захиалагчийн тавьсан шаардлагад нийцэх 100 БЖДҮЭ-ийг сонгоно. Үүнд:

2.1. Мэдээллийн сангаас авах тайлангийн хувилбаруудыг захиалагчийн шаардлагын дагуу тодорхойлох
2.2. Шаардлагын дагуу бүртгэгдсэн мэдээлэл, өгөгдлүүдийн хамаарлыг тодорхойлж мэдээллийн санг бүрдүүлж дуусгах
2.3. Судалгаагаар цугларсан мэдээллийн нэгтгэлд дүн шинжилгээг цогцоор нь хийж танилцуулах. Нөлөөлөх хүчин зүйлсийг үнэлж, тайланг боловсруулах
2.4. Шалгуур үзүүлэлтүүдэд тэнцсэн 100 БЖДҮЭ-ийн мэдээллийг нэгтгэж танилцуулах.
2.5. Захиалагчийн тавьсан шаардлагад нийцэх 100 БЖДҮЭ-ийг сонгон шалгаруулах заавар, аргачлалыг тодорхойлох
2.6. Шаардлага хангасан 100 БЖДҮЭ-ийн нэгдсэн мэдээллийг танилцуулах
2.7. Ярилцлаганд уригдах 100 БЖДҮЭ-ийн дэлгэрэнгүй мэдээллээр хангах.

Гуравдугаар зорилт: Сонгогдсон 100 БЖДҮЭ-ийг 2-р шатны анкет судалгаа, бүлгийн ярилцлагад урьж захиалагчийн шаардлагад нийцсэн, цаашид төслийн хүрээнд зохион байгуулагдах барилгын ажил, бизнесийн менежмент чиглэлээр дадлагажуулах сургалтанд хамрагдах 50 БЖДҮЭ-ийг сонгон шалгаруулна. Үүнд:

3.1. Мэдээллийн сангаас сонгосон 100 БЖДҮЭ -ээс шаардлагатай нэмэлт мэдээлэл цуглуулах анкет, асуултуудыг туршилт хийж сайжруулан боловсруулах
3.2. Боловсруулсан анкет, асуултыг захиалагчаар шалгуулах
3.3. Группийн ярилцлага авахад оролцох талуудад мэдээлэл өгөх
3.4. Группийн ярилцлагыг төлөвлөж, зохион байгуулах
3.5. Судалгааны үр дүнг нэгтгэж захиалагчийн тавьсан шаардлагад нийцсэн 50 ББЖДҮ -ийг мэдээлэл бүхий тайланг танилцуулах
3.6. Судалгааны нэгдсэн дэлгэрэнгүй тайланг Захиалагчийн шаардлагад нийцүүлэн цахим болон хэвлэмэл хувилбараар хүлээлгэж өгөх.

Хүлээгдэж буй үр дүн

1.1. Судалгааны үр дүнд “Улаанбаатар хотын төлөвлөгдөөгүй бүсэд эрчим хүчний хэмнэлттэй орон сууцыг барихад зөвлөгөө өгөх, санхүүгийн зуучлалын үйлчилгээг үзүүлэх” төслийн зорилгын хүрээнд тавигдах шаардлагад нийцэх үзүүлэлт бүхий БЖДҮЭ-ийг тодорхойлох
1.2. Барилгын салбарын БЖДҮЭ-ийн нөөц, чадавхи, сонирхлыг үнэлэх боломж бүхий мэдээллийн санг бүрдүүлэх
1.3. Эхний 100 БЖДҮЭ-ийг сонгох
1.4. Сүүлийн 50 БЖДҮЭ-ийг сонгох

1.2. Судалгааны бэрхшээл

Тус судалгаа нь цаг үеийн хувьд тохиромжгүй цагийг сонгосон дутагдалтай. Өөрөөр хэлбэл цаг агаарын байдал хүйтэрсэн, барилгын ажлууд ихэнх нь зогссон байдалтай байх цаг үетэй давхацсан. Иймд аль болох богино хугацаанд олон хүнтэйгээр судалгааны ажлыг зохион байгуулах шаардлага үүсч байгаа.



Зураг 1. Бригадууд цайны цагаар судалгаа өгч буй байдал

Мөн нөгөө талаас барилгын салбар нь тухайн ажлын байран дээрээ судалгаа өгөөд зогсоод байх боломж нөхцөл аюулгүй байдал талаасаа ч цаг хугацааны талаасаа ч хангалтгүй байгаа нь судалгааны үр дүнг бүрэн гүйцэд асуух боломжийг тэр бүр олгохгүй байна. Иймд цаг хугацаанаас хамаараад зөвхөн цайны цагаар, эсвэл ажил эхлэхээс өмнө, ажил дууссаны дараа барилгын объект руу нэвтэрч судалгаа авах боломж бүрдэж байна.

Зураг 2. Бригадын гишүүд судалгаа өгч буй байдал

1.3. Судалгааны түүвэрлэлт, хамрах хүрээ

Судалгааны ажлыг Улаанбаатар хотын төвийн 6 дүүргийг хамруулж гүйцэтгэсэн бөгөөд захиалагч байгууллагын санал болгосны дагуу 300 ББЖДҮ, мөн цаашид барилгын салбарт ажиллах сонирхолтой 500 иргэн байхаар тооцоолсон.

Бусад оронд үүнтэй адил төслийг хэрэгжүүлсэн туршлагаас үзвэл барилгын салбарт үйл ажиллагаа явуулж буй бригадуудаас гадна цаашид энэ салбарт ажиллах сонирхолтой иргэдийг оруулж ирэх нь илүү хямд, тогтвортой ажиллах хүч байхыг үгүйсгэхгүй юм. Монгол улсын хувьд барилгын салбарын ажиллах хүчний дийлэнхийг хямд ажиллах хүч талаас хувь хүмүүс бүрдүүлдэг. Барилгын ажлын туршлагатай иргэдийг судалгаанд хамруулах нь төслийн үр дүнд хэрэгтэй байх магадлалтай гэж төслийн захиалагч нартай зөвшилцсөний үндсэн дээр судалгааны нэг зорилтот бүлэг болгож авсан.

Иймд судалгааны баг нь зорилтот бүлэгт түлхүү хүрдэг сошиал медиа, ФМ радио, өдөр тутмын болон зарын сонинууд, захиалагчийн болон мэдээллийн вэб сайтууд зэргээр зар сурталчилгаа, төслийн танилцуулга- видеог түгээж судалгааны цар хүрээг нийт зах зээлд нэмэгдүүлсэн. Энэ нь төслийн зорилгод нийцсэн, гэр хорооллын барилгын дулаан алдагдлыг бууруулах технологийн шийдэлд суралцах, цаашид ажиллах сонирхлоо сайн дурын үндсэн дээр илэрхийлсэн иргэдийг хамруулах нөхцөлийг бүрдүүлсэн.

Судалгаанд хамрагдах барилгын салбарын ААНБ-ыг зорилтот олон шатлалт бүлэглэсэн түүврийн (multi-stage stratified sampling) аргаар сонгосон.

1.4. Туслах судлаачдыг бэлтгэх сургалтын үйл ажиллагаа

Бодитой мэдээлэл цуглуулах нэг үндсэн нөхцөл нь судлаачдаа бэлтгэх явдал байдаг. Иймд судалгаа эхлэхийн өмнө судалгааны арга зүй, гарын авлага, түүвэрлэлт болон асуулгын хуудас, судалгааны ажлыг хэрхэн эхлүүлэх, хяналт хийх талаар судлаачдын сургалтыг зохион байгуулж ажилласан.

Зураг 3. Судлаачдад судалгааны арга зүйн сургалт өгч буй байдал

Сургалтаар судалгааны мэдээлэл цуглуулах, түүвэр судалгаанд хамрагдах оролцогчдоос асуух асуулгын хуудасны үндсэн агуулгыг ойлгуулах, судалгааны мэдээлэл цуглуулах үеийн арга зүй, техник, судалгааны асуулгын мөн чанар, ойлголтуудын талаар нэгдмэл ойлголтод хүргэх зэрэг өргөн хүрээний асуудлуудыг багтаасан.

Туршилт болон үндсэн судалгааны мэдээлэл цуглуулах үйл ажиллагаанд ажиллах ахлагч, судлаачдад зориулсан сургалтыг 2018 оны 11-р сарын 05-ний өдөр ШУТИС–ийн БАТС-ийн сургалтын танхимд зохион байгуулсан. Сургалтад судалгааны агуулга, зорилго, зорилт болон судалгааны асуулгыг бөглөх дэлгэрэнгүй зааварчилгаг өгөв.

1.5. Судалгааны асуулга, ярилцлагын хуудасны бүтэц

Судалгааны асуулгын хуудсыг оролцогч талуудын сонирхол, ажлын үр дүнд тулгуурлан боловсруулсан. Мөн асуулгын хуудсыг Монгол улсын онцлогт тохируулан ЖЭРЭС байгууллагын төсөлд оролцогч талуудын санал, өмнө өөр оронд хэрэгжүүлж байсан зөвлөхүүдийн санал, нөхцөл байдлыг тусгах замаар нэмэлт засваруудыг хийж шинэчлэн найруулсан.

Барилгын салбарт үйл ажиллагаа явуулж буй бригад буюу БЖДҮЭ-ийн нөөц, чадавхи, сонирхлыг тодорхойлох судалгааны асуулга

Тус асуулгын хуудас нь нийт 43 асуултаас бүрдсэн. Судалгааны асуулга нь дараах хэсэгт хуваагдана. Үүнд:

1) Бригад, байгууллагын талаарх мэдээлэл;
2) Бидний санал тавьж буй ажилд оролцох сонирхол;
3) Гэр хорооллын байшинг дулаалах ажлыг сонирхож буй бол тухайн бригадын ахлагчаас ярилцлага авах зэрэг болно.

Дээрх асуулгаар туршилтын судалгааг явуулсан ба туршилт судалгааны үр дүнд асуулгын хуудасны загвар болон зарим нэмэлт өөрчлөлтийг оруулсан.



Зураг 4. Судлаачдад арга зүйн сургалт, туршилт судалгаа

1. Иргэнээс авах судалгааны анкет /барилгын салбарт ажиллах сонирхол бүхий/

Тус асуулгын хуудас нь нийт 43 асуултаас бүрдсэн (Хавсралт 3). Судалгааны асуулга нь дараах 4 бүлэгт хуваагдана. Үүнд:

1) Ерөнхий мэдээлэл;
2) Ажлын туршлага, ур чадвар;
3) Оролцогчийн сонирхол;
4) Сургалт, санхүүгийн хэрэгцээ;

Дээрх асуулгаар туршилтын судалгааг явуулсан ба туршилт судалгааны үр дүнд асуулгын хуудасны загвар болон зарим нэмэлт өөрчлөлтийг оруулсан.

1.6. Туршилтын судалгаа, түүний зохион байгуулалт

Туршилтын судалгааг үндсэн судалгааны жижиг хувилбар байдлаар явуулсан бөгөөд үндсэн судалгааг гүйцэтгэхээр санал болгосон арга зүй аргачлалыг нарийн дагаж мөрдсөн. Туршилт судалгааны түүврийн хамрах хүрээ нь Улаанбаатар хотод барилгын салбарт үйл ажиллагаа явуулж буй 10 бригад, 20 иргэн байхаар сонгосон. Туршилтын судалгааны мэдээлэл цуглуулалтыг боловсруулсан асуулгын дагуу авсан

бөгөөд судалгаанд ганцаарчлан ярилцах замаар асуулгын хуудсыг сайжруулахад хэрхэн анхаарах асуудлыг нягтлан судалсан.

1.6.1. Судалгааны мэдээлэл цуглуулах ажлын зохион байгуулалт

Статистик арга аргачлалын дагуу түүвэрлэн авсан оролцогчоос асуулга, анкетын дагуу бэлтгэгдсэн судлаач (ярилцлага авагч) судалгааг авсан. Судлаач тухайн судалгаанд оролцогчоос батлагдсан асуулгын хуудасны асуултуудыг нэг бүрчлэн асууж, асуулгын хуудас дээр бөглөх зарчмаар мэдээллийг цуглуулсан болно (Зураг 5-6).

Зураг 5. Батлагдсан асуулгын дагуу судалгаа авч буй нь

Туршилтын судалгааны мэдээлэл цуглуулах үйл ажиллагаа 2018 оны 10-р сарын 25-26-ний өдрүүдэд зохион байгуулсан. Цуглуулсан мэдээллийг тухай бүрд нь нэг бүрчлэн шалгасан ба 100 хувь утсаар хяналт хийсэн.

Зураг 6. Судалгааны явц

1.6.2. Судалгааны мэдээлэл боловсруулалт

Мэдээлэл шивэлтийг статистик судалгааны SPSS 22 програм ашиглан хийв. Мэдээлэл оруулах програмыг SPSS багц програмын сүүлийн хувилбарын мэдээлэл оруулах хэрэгсэл [1] болон мэдээллийг шалгах засварлах багцын тусламжтайгаар боловсруулсан. Мэдээлэл оруулах үеийн шалгалтуудыг дараах байдлаар гүйцэтгэсэн (Зураг 7-8).



Зураг 7. Мэдээллийн санг бэлдэх явц, судлаач-операторуудад зааварчилга өгч буй нь

Үүнд:

1. Мэдээлэл оруулах явцад хариулт орхигдохоос сэргийлэх үүднээс заавал хариулах асуулт бүр дээр хариултыг заавал оруулахыг сануулах
2. Хариултад байхгүй код оруулах болон оруулсан утга нь тодорхой хязгаарт багтахгүй байх тохиолдолд анхааруулах.

Програмын дагуу мэдээллийг оруулж дууссаны дараа SPSS програмын алдааг илрүүлэх[2] хэрэгслийг ашиглан дараах шалгалтуудыг хийв. Үүнд:

1. **Ердийн шалгалт**: Бүх асуулт бүрэн хариулагдсан эсэх болон үсрэлт зөв байгаа эсэхийг шалгах;
2. **Үнэмшилтэй утгын шалгалт**: Байж болох утгаас давсан онцгой утга байгаа эсэхийг шалгах;
3. **Статистик анализад тулгуурлагдсан хамаарлын болон логик шалгалт**: Утгуудын хоорондын уялдаа, логик холбоо, утгуудын нийлбэр нийт дүнтэй тэнцүү эсэхийг шалгах;
4. **Мэдээлэл оруулах програмын шалгалт**: Үүнд ердийн шалгалт, үнэмшилтэй утга болон хамаарлын шалгалтууд хамаарна;
5. **Мэдээлэл шалгах програмын шалгалт**: Мэдээлэл оруулах програмын шалгалт ба бусад нэмэлт шалгалтууд.

[1] Мэдээлэл оруулах хэрэгсэл - (Data entry tools)
[2] Алдааг илрүүлэх зорилго бүхий Batch edit хэрэгсэл ашигласан.

Мэдээллийг оруулж дууссаны дараа SPSS[3] 22.0 програмаас үзүүлэлтүүдийг гарган авч POWER BI программ дээр боловсруулалт хийж судалгааны өгөгдлийн санг үүсгэн ажиллалаа (Зураг 8).

Зураг 8. Мэдээллийн санг нэгтгэх, хянах явц

[3] SPSS - Statistical Package for the Social Sciences

БҮЛЭГ 2. СУДАЛГААНД ХАМРАГДСАН БЖДҮЭ-ИЙН (бригадуудын) СУДАЛГААНЫ ҮР ДҮН

1990-ээд оныг хүртэл барилгын мэргэжилтэй ажилчид аль нэг барилгын байгууллагад харьяалагддаг, тухайн байгууллага нь ажилчдаа мэргэжлийн чиглэлээс нь шалтгаалан бригадуудад хуваарилан, нэгдсэн зохион байгуулалттай ажилладаг байлаа. Харин зах зээлийн эдийн засагт шилжсэнээс хойш Монгол орны барилгачид тархай бутархай, тодорхой харьяалалгүй, чөлөөт бригадууд бий болсон. Албан бус эх үүсвэрээр өнөөдөр барилгын 22 гаруй мянган мэргэжилтэй ажилчид, 10 гаруй мянган барилгын гол бүтээн байгуулагч бригад зохион байгуулалтгүй, улс орон даяар ямар нэгэн хараа хяналтгүй тархан, барилга барьсаар байна.

Судалгааны явцад бригадууд нь хөрөнгө оруулагч, захиалагч, гүйцэтгэгч байгууллагатай гэрээтэй, гэрээгүй ажилласаар авч ажлаа дуусаны дараа хөдөлмөрийн хөлсөө авч чадахгүй хохирох нь элбэг байдаг байна. Нийт судалгаанд оролцогчдын 89 (41%) нь сүүлийн 3 жил ажлынхаа хөлсийг авч чадаагүй дунджаар 3 тохиолдол байгааг илэрхийлсэн байна. Мөн бригадуудтай байгуулж буй ихэнх гэрээнд цалин хөлс, хөдөлмөр хамгаалал, хамгаалалтын хувцас зэргийг бригад өөрсдөө хариуцна гэж заасан байдаг байна. Түүнчлэн бригадууд нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгал, ослоос урьдчилан сэргийлэх даатгал, хүн амын орлогын татвар зэрэг ямар нэгэн татвар татаас улсад төлдөггүй нь энэ судалгаагаар нотлогдож байна.

Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй бригадуудын судалгааг авах үйл ажиллагаа 2018.11.12-с эхэлсэн. Энэ нь барилгын ажил улирлын чанараас хамааран зогсох цаг үетэй давхцаж байсан учраас гэрээнд заагдсан Улаанбаатар хотын 6 дүүрэг болох Баянгол, Сүхбаатар, Баянзүрх, Хан-Уул, Сонгинохайрхан, Чингэлтэй дүүргээс өргөтгөн бусад дүүрэг, зарим боломжтой аймагт үйл ажиллагаа явуулж буй цөөн хэдэн бригадыг оролцуулан судалгааг авсан. Мөн нөгөө талаас хангалттай бригадуудыг олж судалгааг авах асуудал тодорхой биш (богино хугацаа, улирлын чанартай зогсолт зэргээс шалтгаалан) байсны улмаас барилгын салбарт ажиллах сонирхолтой иргэдийг оролцуулан авахаар судалгааны багууд харилцан тохиролцсон. Энэ бүхэн нь гэр хорооллыг дулаалах ажиллагааг ажиллах хүчээр тогтвортой хангах асуудал руу чиглэсэнд оршино.

Судалгаанд 224 бригад хамрагдсанаас хүчинтэй анкетийн тоо 217 байна. Бригадын хүчинтэй анкетаар өгөгдлийн санг SPSS, POWER BI программууд дээр үүсгэлээ (Зураг 53-64)



Зураг 9. Бригадуудын үйл ажиллагаа явуулж буй байршил, дүүргээр

Судалгааны хүчинтэй анкет бүхий 217 бригадын 44 нь буюу нийт судалгаанд оролцогчдын 20 % нь Баянзүрх, 44 (20 %) нь Сонгинохайрхан, 36 (17 %)[4] нь Хан –Уул, 26 (12 %) нь Сүхбаатар, 23 (11%) нь Баянгол, 20 (9 %) нь Чингэлтэй дүүрэгт үйл ажиллагаагаа явуулж байгаа бригадууд хамрагдсан (Зураг 9). Бригадын зохион байгуулалтаар ажиллаж буй иргэд нь ажил хаана олдоно тийшээ очиж ажилладаг тул сонгох бригадуудын тоо захиалагчийн тоонд хүрэхгүй байх эрсдэлээс сэргийлэх, мөн нөгөө талаас судалгааны хугацаа барилгын улирлаас шалтгаалан зогсох үетэй давхцаж байсан учраас үндсэн 6 дүүргээс гадна Налайх, Багануур, Багахангай болон бусад орон нутаг дахь бригадуудыг судалгаанд хамрагдсан байна. Энэ нь нийт судалгааны 11 орчим хувийг эзэлж байна.

Өнөөдөр барилгын салбарт дараах 12 төрлийн чиглэлээр дагнасан бригадууд үйл ажиллагаа явуулж байна. Бригадын гишүүдийн тоо ажлын цар хүрээнээс хамаарч тодорхойлогддог хувьсамтгай шинжтэй байгаа ажиглагдсан. Судалгаанаас харахад нэг бригад дунджаар 4 үндсэн гишүүнтэй бөгөөд 10-20 мөн түүнчлэн 140 хүнтэй болтлоо өргөжин ажиллах боломжтой байна. Өөрөөр хэлбэл 4 үндсэн хүнтэй баг дээрээ тулгуурлаад туслан гүйцэтгэх бусад хүмүүсийг зараар нэмж аван тухайн ажлыг бригадаар гүйцэтгэж байна гэсэн үг юм.

[4] 36 –оролцогчдын тоо, 17 %-оролцогчдын хувь гэж цаашид ойлгоно.

Өрлөгийн бригад

Шаврын бригад

Мужааны бригад

Каркас угсралтын бригад

Дотоод заслын бригад

Гадна Фасадны бригад

Цахилгааны бригад

Арматурын бригад

Сантехникийн бригад

Дээврийн бригад

Гагнуурын бригад

Чулуу плитаны бригад

Дулаалгын бригад

Эрэлт: Улаанбаатар хотод 160000 байшин болон орон сууцны айлууд дулаан алдагдалтай амьдарч байна.

Харин бидний зорилтот ажил болох дулаан алдагдлаар мэргэшин айл бүр дэх дулаан алдагдлыг тооцоолж, түүнд тохирсон шийдлүүдийг бий болгон, түүний дагуу сургалтыг явуулж дулаалга хийх нь дулаалгын бригадыг үүсгэн ажлын байртай болгох боломжийг бүрдүүлэх юм.



Зураг 10. Байшингийн дулаан алдагдлын төрлүүд

ШИГТГЭЭ. Барилгын дулаан тусгаарлалт муу байх тусам барилгаас алдагдах дулааны хэмжээ ихсэж, тэр хэмжээгээр халаалтад эрчим хүч өндөр зарцуулдаг. Амины орон сууцыг ихэнх тохиолдолд барилгын зураг төсөлгүй барьдгаас дулаалгыг туйлын хангалтгүй хийх ба үүнээс хамааран халаалттай холбоотой хүндрэл, зардал өндөр гарч ая тухтай амьдрах нөхцөл алдагдаж улмаар дулаан байх үүднээс их хэмжээний нүүрс хэрэглэж агаарын бохирдлыг нэмэгдүүлж байна. Барилгын дулаан 2 замаар алдагддаг.

Дулаан шилжүүлэлтээр. Барилгын хана, тааз, шал зэргийг хэр зэрэг сайн дулаалснаас хамаарч энэ алдагдлын хэмжээ өөрчлөгддөг. Шилэн хөвөн, хөөсөнцөр, эсгий, эрдэс хөвөн, модны үртэс зэрэг нь дулааныг муу дамжуулдгаас сайн дулаалга болно. Тиймээс барилгын хийцүүдэд эдгээр материалыг ямар нэгэн байдлаар заавал нэмэлт дулаалга болгон ашиглавал дээрх алдагдлыг багасгана.

Нийт дулаан алдагдлын 25 хувь нь цонхоор, 25 хувь нь ханаар, 35 хувь нь тааз буюу хучилтаар, 10 хувь нь орчим нь шалаар алдагддаг (Зураг 10).

Агаар нэвтрүүлэлтээр. Барилга угсралтын ажлыг чанаргүй, технологийн дагуу гүйцэтгээгүйгээс болон чанаргүй хийц /тухайлбал цонх/ сонгосноос голчлон хаших бүтээцүүдийн уулзвар /хана-цонх/ хэсгүүдээр нүх сүв гарна. Энэхүү нүх сүвээр хүйтний улиралд гаднаас хүйтэн агаар орж ирэх бөгөөд үүнийг халаахад их хэмжээний эрчим хүч зарцуулах болно. Нийт дулаан алдагдлын 25-35 хувь нь үүнд хамаарна.

Тус судалгаанд 76 нь буюу 36.2% нь барилгын тусгай зөвшөөрөлтэй ХХК, 31 нь буюу 14.8% нь тусгай зөвшөөрөлгүй ХХК, 91 нь буюу 43.3 % зөвшөөрөлгүй бригад, харин 19 (8.7%) нь ямар статустай болохоо тодорхойлж мэдэхгүй бригадууд хамрагдсан Бригадын ахлагч нар нь ихэвчлэн 177 (83.1%) эрэгтэйчүүд байна.



Зураг 11. Бригадуудын үйл ажиллагааны чиглэл

Бригадуудын үйл ажиллагаа явуулж буй чиглэлийг дээврийн, хаалга цонх, шал суурилуулах, барилгын гадна ханын дулаалга, фасад, угсралт, цутгалт, өрөг, өрлөг, шавар, дотор засал, сантехник, цахилгааны ажил, холбоо дохиолол автоматжуулалтын болон бусад гэсэн 10 төрлийн үйл ажиллагаагаар авч үзсэн. Бригадууд хэд хэдэн төрлийн үйл ажиллагааг эрхэлж байгаа нь судалгаанаас харагдаж байна.

Судалгаанд хамрагдсан бригадуудын (үйл ажиллагааны давхардсан тоогоор) 107 нь буюу 13.9 % нь шавар, дотор засал, 103 (13.4 %) нь угсралт цутгалт, 95 (12.3 %) нь өрөг өрлөг, 89 (11.6 %) нь барилгын гадна ханын дулаалга, фасад, 79 (10.3 %) нь сантехник, 67 (8.7 %) нь дээврийн ажил, 60 (7.8%) нь цахилгааны ажил, 49 (6.4%) нь холбоо дохиолол, автоматжуулалт зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэдэг байна (Зураг 11).

Судалгаанд 5 хүртэл жилийн ажлын туршлагатай 39 (22 %) бригад, 6–9 жилийн туршлагатай 104 (58 %), 10–15 жилийн туршлагатай 32 (18%), мөн 16–с дээш жилийн туршлагатай 6 бригад (2%) хамрагджээ. Барилгын салбарт ажилласан ажлын туршлагатай бригадууд тус тус оролцсон байна.



Зураг 12. Бригадуудын барилгын салбарт ажилласан туршлага, жилээр

Бригадын гишүүдийн тоо харьцангуй адилгүй буюу 132 (61%) нь 9 хүртэл гишүүнтэй, 51 (24%) нь 10–19 гишүүнтэй, 20-29 гишүүнтэй 17 (8%) нь, 30 – 39 гишүүнтэй 8 (4%), 40-с дээш гишүүнтэй нь 4% -ийг эзэлж байна. Үүнээс үзвэл бригадуудын үндсэн гишүүдийн тоо ихэвчлэн 3-6 хүн байх бөгөөд туслах гишүүн нь шаардлагатай үед нэмэгдэж бригад нь 140 гишүүнтэй болтлоо өргөжих тохиолдол байна. Судалгаа авах үед буюу 11 сард ихэнх барилгууд үйл ажиллагаагаа зогсоосон, эсвэл халаалтаа аваад дотоод заслын ажил эхэлсэн үе байсан нь ч тухайн үед ажил гүйцэтгэж байсан бригадуудын гишүүдийн тоо, тэдгээрийн ажлын онцлогтой нягт холбоотой юм (Зураг 13, 14).



.

Зураг 13. Судалгаанд оролцогч бригадууд

Барилгын салбар нь улирлын шинж чанартай бөгөөд бригадууд дулааны улиралд буюу гол төлөв 3-12 саруудад үйл ажиллагаа явуулж байна. Өөрөөр хэлбэл, судалгаанд хамрагдсан бригадуудын 150 нь буюу 69% хувь нь 3–12 саруудад ачаалал ихтэй ажилладаг байна. Мөн судалгаанд оролцогчдын 50 нь буюу 23% нь жилийн дөрвөн улиралд үйл ажиллагаа явуулдаг байна. Энэ нь нэг талаас барилгын салбар дахь үйл ажиллагаа орчин үеийн арга техник ашиглан жилийн дөрвөн улиралд үйл ажиллагаа явуулдаг, нөгөө талаас бригадууд өөр төсөлд дотоод засал чимэглэлийн үйл ажиллагаанд оролцож байгаатай холбоотой.



Зураг 14. Судалгаа авах үеийн бригадын үндсэн гишүүдийн тоо

Өөрөөр хэлбэл бригадууд жилийн 4 улиралд ямар нэгэн ажлаар хангагдан ажиллахыг хүсч байна. Мөн энэ хэмжээгээрээ ийм чиглэлээр мэргэшин ажиллахыг чармайж байгаа нь судалгааны явцад харагдаж байна. Харин судалгаанд хамрагдагсдын 17 нь буюу 8 % нь зөвхөн 4–6 саруудад үйл ажиллагаагаа идэвхитэй явуулдаг байна. Эдгээр нь гол төлөв дээврийн ажил гүйцэтгэдэг бригадууд юм (Зураг 15).



Зураг 15. Бригадын үйл ажиллагаа идэвхитэй явагддаг сар

Нийт бригадын 70 хувь нь жилийн 30 сая хүртэл төгрөгний орлоготой ажилладаг байна. Бригадын жилийн орлогын талаар нийт бригадын 15 (14.9%) нь 5 сая хүртэл төгрөг, 14 (13.9%) 5.1 – 10 сая төгрөг, 10 (9.9%) нь 10.1 – 15 сая төгрөг, 19 (18.8%) нь 15.1 – 20 сая төгрөг, 13 (12.9%) нь 20.1 – 30 сая төгрөг, 12 (11.9%) нь 30.1- 50 сая, 7 (6.9%) нь 50.1- 100 сая төгрөг, 11 (10.9%) нь 100.1 саяас дээш төгрөгийн жилийн орлоготой байдаг гэж хариулсан байна (Зураг 16). Энэ нь үйл ажиллагааны чиглэл болон хийж буй төслүүдээс хамааралтай байгаа нь ажиглагдаж байна.



Зураг 16. Бригадуудын жилийн нийт орлого

Барилгын ажлыг ихэвчлэн гүйцэтгэлээр нь үнэлж байгаа бөгөөд туслах ажилтнуудын хувьд өдрийн хөлс олгодог байна. Бригадын нэг гишүүний нэг өдрийн хөлсийг судалгаанд оролцогчдын 146 нь буюу 74 % нь 50 хүртэл мян.төг, 40 (20%) нь

50.001 – 150.000 төг, 3 (1.5%) нь 150.001-250.000 төг, 9 (4.5%) нь 250.001 – с төгрөг гэж тодорхойлсон байна(Зураг 17).



Зураг 17. Ажилтай үеийн нэг гишүүний нэг өдөрт олж буй орлого дунджаар

Бригадуудын жилийн орлогыг үйл ажиллагаа явуулж буй хэлбэр хэрхэн нөлөөлж байгааг авч үзэхэд ХХК, барилгын тусгай зөвшөөрөлтэй, зөвшөөрөлгүй эсэхээс үл хамаарч харин тухайн үед хийж буй ажлын хэмжээнээс хамаарч байна (Хүснэгт 3). Зарим оролцогчид албан ёсны хуулийн этгээд байх нь ажил олоход илүү боломжтой гэдэг боловч ажлын хөлсөнд нөлөөлдөггүй байх магадлалтай байна.

Хүснэгт 1. Бригадын жилийн орлого, аж ахуйн хэлбэрээр

Жилийн орлого	ХХК	Барилгын тусгай зөвшөөрөлтэй	Зөвшөөрөлгүй	Мэдэхгүй	Нийт
5 сая хүртэл	4 (26.7%)	5 (33.3%)	5 (33.3%)	1 (6.7%)	**15 (15.3%)**
5.1 - 10.0	1 (7.7%)	6 (46.2%)	6 (46.2%)	0	**13 (13.3%)**
10.1 - 15 .0	2 (22.2%)	2 (22.2%)	5 (55.6%)	0	**9 (9.2%)**
15.1 - 20.0	3 (16.7%)	7(38.9%)	7(38.9%)	1 (5.6%)	**18 (18.4%)**
20.1 – 30.0	2 (15.4%)	6 (46.2%)	5 (38.5%)	0	**13 (13.3%)**
30.1 – 50.0	0	6 (50.0%)	6 (50.0%)	0	**12 (12.2%)**
50.1 – 100.0	1(14.3%)	3(42.9%)	3(42.9%)	0	**7 (7.1%)**
100.1 – 150.0	0	2(66.7%)	1(33.3%)	0	**3 (3.1%)**
150.1 -с дээш	1 (12.5%)	5(62.5%)	1(12.5%)	1(12.5%)	**8 (8.2%)**
Дүн	**14 (14.3%)**	**42(42.9%)**	**39(39.8%)**	**3(3.1%)**	**98 (100.0%)**

Доорх хүснэгтээс харахад бригадын олж буй орлого мөн гишүүдийн тооноос үл хамаарч байна (Хүснэгт 4, 5).

Хүснэгт 2. Бригадын жилийн орлого, гишүүдийн тоогоор

Жилийн орлого (сая төгрөг	Бригадын гишүүдийн тоо						Дүн
	9 хүртэл гишүүнтэй	10 - 19 гишүүнтэй	20 - 29 гишүүнтэй	30 - 39 гишүүнтэй	40 - 49 гишүүнтэй	50 - с дээш гишүүнтэй	
5 сая хүртэл	13(76.5%)	3 (17.6%)	0	0	0	1 (5.9%)	**17**
5.1 - 10.0	8 (66.7%)	3 (25%)	1 (8.3%)	0	0	0	**12**
10.1 - 15 .0	4 (40%)	4 (40%)	0	1 (10%)	0	1 (10%)	**10**
15.1 - 20.0	9 (42.9%)	10 (47.6%)	1 (4.8%)	1(4.8%)	0	0	**21**
20.1 – 30.0	8 (66.7%)	4 (33.3%)	0	0	0	0	**12**
30.1 – 50.0	7 (70%)	2 (20%)	1 (10%)	0	0	0	**10**
50.1 – 100.0	5 (62.5%)	1 (12.5%)	2 (25%)	0	0	0	**8**
100.1 – 150.0	1 (50%)	0	1 (50%)	0	0	0	**2**
150.1 -с дээш	3 (37.5%)	3 (37.5%)	1 (12.5%)	1(12.5%)	0	0	**8**
Нийт	**58**	**30**	**7**	**3**	**0**	**2**	**100**

Бригадын гишүүд нь зөвхөн Улаанбаатарын (68%) харьяалалтай бус хөдөө орон нутгаас (48%) давхардсан (орон нутгаас шилжиж ирээд хотын иргэншил хүлээж буй, *түр оршин суугч*) тоогоор маш их иргэд ирж ажиллаж байна, ялангуяа туслах ажилтнууд (Зураг 18).



Зураг 18. Бригадын гишүүдийн харьяалал

Хүснэгт 3. Барилгын ажлын үнэлгээ, 2018.12.26-ны байдлаар

№	Ажлын нэр	Хэмжих нэгж	Үнэ, ханш /төгрөг/		
			Компани	Бригад	Хувь хүн
	Газар шороо, суурин ажил				
1	Газар шорооны ажил /техникээр/	м3	10000-13500		
2	Газар шорооны ажил /гараар/	м3	40000-50000		
	Механизм ажлын хөлс				
3	Экскаваторын ажлын хөлс	цаг	81250-120000		
4	Ковшны ажлын хөлс	цаг	70000-110000		
	Барилга угсралт				
5	Бүрэн цутгамал /Компани/	м2	130000-150000	60000-110000	70000-90000
6	Карказ угсралт /Компани/	м2	115000-130000	45000-70000	
7	Суурин угсралт	м2	45000-75000	30000-90000	70000-80000
8	Карказ угсралт/Хэв хашмалтай/	м2	103500-126500	80000-100000	
9	Шавар/гадна/	м2	12000-14000	8000-13000	8000-10000
10	Шавар/дотор/	м2	10000-12000	8000-10000	5000
11	Тоосгон өрлөг/38-н/	м3	35000-45000	30000	25000
12	Тоосгон өрлөг /25-н/	м2	20000-22000	22000	25000
13	Тоосгон өрлөг /12-н/	м2	10000-12500	9000-12000	7000
14	Блокон өрлөг	м3	19800-24200		
	Засал чимэглэл				
15	Гадна чулуун фасад	м2	75000	40000-60000	35000-45000
16	Гадна шилэн фасад угсралт	м2	60000-120000	80000-85000	
17	Гадна хөөсөн фасад хийх	м2	25000-35000	18000-23000	25000-35000
18	Гадна сайдинг фасад хийх	м2	25000-35000	13000-18000	15000
19	Чулуун шал тавих	м2	25000-35000	16000	20000
20	Чулуун шат тавих	м2	18000-30000	16000	20000
21	Хананы плита тавих	м2	10000-15000	8000-10000	8000
22	Ус тусгаарлагч тавих	м2	3000-3500	2000	2000
23	Цагаан замаска /2үе/	м2	3500-4500	3000-3500	3000
24	Багана дам нурууны тэгшилгээ хийх /шавардлага/	м2	9000-12000	7000	7000
25	Таазны тэгшилгээ хийх	м2	4500	4000-6000	4500
26	Кнапны наалт	м2	1500	1500	1000
27	Зүлгүүр	м2	1500	1000	1000
28	Эмульс /гадна/	м2	4500-7500	4000-7000	3000
29	Эмульс/дотор/	м2	4000-4500	3500	1500
30	Обой наах	м2	5000-6000	3000-4000	2500-3000
31	Будаг будах	м2	4000-5000	2000-3000	1500
32	Хаалга суулгах/гадна/	ш	45000	15000-25000	18000
33	Хаалга суулгах/дотор/	ш	25000-35000	25000	10000-15000
34	Хулдаас наах	м2	6000	6000	2500-3500
35	Паркет, ламинатан шал шахах	м2	4500-5500	5000	3000-4500
36	Шалны бетон тэгшилгээ	м2	6500-8000	10000	5000
37	Цонхны амалгаа хийх	ш	15000-20000	9000-15000	10000-15000
38	Дээврийн ажил	м2	25000-35000	18000-28000	18000

Эх сурвалж: Барилга.мн сайтаас

Барилгын салбарт гадаадын иргэн, компани, бригад, хувь хүн гэсэн 4 төрлийн субъектүүд оролцож ажиллаж байгаа хэдий ч зах зээл дээр тэдгээрийн үнэлэмж, чанар, гүйцэтгэл өөр, өөр түвшинд байгааг судалгаанд оролцогчид онцолж байна. Тухайлбал, гадаадын иргэдийн ажлын хөлс ойролцоогоор 2 дахин илүү үнэлгээтэй байна. Нөгөө талаас компаниуд нийгмийн даатгал тогтвортой төлдөггүй, ажиллах хүчнээ байнгын хөгжүүлэх боломжийг олгохгүй байгаа учир барилгын ажилчид бригадын системээр оршин тогтнож байна. Эдгээр нь мөн бригадын хэмжээ болон үйл ажиллагаа нь хувьсамтгай байх үндсэн шалтгаан юм.

Судалгаанд оролцогчдын (бригадын ахлагчуудын) 110 нь буюу 56% нь бригадын үйл ажиллагаанд зориулж машин тоног төхөөрөмж авахдаа зээл авсан байна. Зээлийн хэмжээ дунджаар 2-20 сая орчим төгрөг байна.

Бригадын гишүүдийн нийгмийн байдлыг судалж үзвэл ихэнхи нь хашаа байшинд оршин суудаг байна (Зураг 19). Тодруулбал, гишүүдийн 184 (37 %) нь гэрт, 176 (35 %) нь байшинд, 141 (28 %) нь орон сууцанд амьдарч байна.



Зураг 19. Бригадын гишүүдийн амьдарч буй сууцны төрөл

Барилгын салбарт ялангуяа бригадуудад түгээмэл тохиолддог асуудлын нэг нь гүйцэтгэсэн ажлын хөлсөө авч чадахгүй явдал юм. Энэ нь нэг талаас бригадуудын чадвар, чанартай холбоотой байдаг хэдий ч нөгөө талаас захиалагч, гүйцэтгэгч 2-ын харилцан тохиролцоо, ойлголцол, хүлээлтийн зөрүү их байгааг харуулж байна. Мөн барилгын салбар дахь хөрөнгө оруулалт тогтвортой биш байдгаас шалтгаалан эхлээд ажлаа гүйцэтгүүлчихдэг, дараа нь захиалагчийн хөрөнгө оруулалт хүлээгддэг зэрэг нөхцөлөөс шалтгаалан ажлын хөлсөө өгөхгүй тохиолдолд ч түгээмэл байгаа юм. Хамгийн гол асуудал нь захиалагч тал гүйцэтгэгч талын эрх зүйн чадвар чадамж муу байгааг далимдуулан хэт нэг талын үзлийг тулгасан ажлын нөхцөл бүхий гэрээгээр ажил гүйцэтгүүлдэг, зарим тохиолдолд гэрээгүйгээр ажил гүйцэтгүүлэх нь ч түгээмэл байна.

Сүүлийн 3 жилийн хугацаанд ажлынхаа хөлсийг авч чадаагүй 3 хүртэл тохиолдол судалгаанд оролцсон бригадуудын 89%-д нь байна (Зураг 20). Харин

ажлынхаа хөлсийг авч чадаагүй 4–7 тохиолдол 9%-д нь, 8-аас дээш удаагийн тохиолдол 2%-д нь тохиолдол байна. Ажлынхаа хөлсийг тогтмол, цаг хугацаандаа авна гэдэг тийм ч амар ажил биш байдаг байна. Мөн нэг төрлийн дагнасан гүйцэтгэл хийдэг, урт хугацаанд түншлэн ажиллаж буй бригад, захиалагчид ч байна. Өөрөөр хэлбэл харилцан ашигтай, чанартай бүтээмжтэй хамтран ажиллаж буй бригад, захиалагчид ч байна. Харин энэ нь тийм олон биш юм.



Зураг 20. Сүүлийн 3 жилийн хугацаанд ажлынхаа хөлсийг авч чадаагүй тохиолдол

Бригадуудад тулгамдаж буй бэрхшээлүүдийн талаар судалгаанд оролцсон бригадуудын 100 (21.4 %) нь санхүүгийн бэрхшээл, 90 (19.3 %) нь хүний нөөцийн хомсдол, 83 (17.8%) нь найдвартай гэрээгээр ажиллаж чаддаггүй, 61 (13.1%) нь ажлын хөлсөө авч чаддаггүй, 44 (9.4%) нь мэргэжлийн чадвар дутмаг, 19 (4.1%) нь зохион байгуулалтгүй зэрэг хүндрэл бэрхшээл тулгардаг гэсэн байна (Зураг 21). Санхүүгийн бэрхшээл, хүний нөөцийн хомсдол 2 хамгийн их хувь эзэлж байна. Үүнийг даван туулахад тухайн салбар луу чиглэсэн бодлого, хөшүүрэг нэн чухал юм. Хамгийн гол нь тогтвортой, урт хугацааны хүнийн нөөцийг тогтвортой хөгжүүлэх бодлого, систем чухал юм.

Харин найдвартай гэрээгээр ажиллаж чадахгүй байгаа хэмээн 18 орчим хувь нь илэрхийлжээ. Үүнийг сайжруулах арга зам нь ажилчдыг эрх зүйн мэдлэг, чадвартай болгох, аливаа ажлаа мэргэжлийн түвшинд бизнесийн зарчмаар хийж, гүйцэтгэж, гүйцэтгүүлж сургах явдал юм.



Зураг 21. Бригадуудад тохиолддог бэрхшээл

Бригадууд ажлын дараагийн захиалгаа гол төлөв өмнөх захиалагчаас 157 (35.5 %) нь, найз нөхөд, түншийн холбоогоор дамжуулан 147 (33.3 %) нь, интернет сайтаар дамжуулан ажлаа олдог нь 37 (8.4 %), FB / сошиал сайт мөн радио FM – 30 (6.8%) гэх зэрэг эх сурвалжуудыг нэрлэсэн байна (Зураг 22).



Зураг 22. Бригадуудын ажлын захиалгаа олдог хэлбэр

Хөдөлмөр зуучлал, зар мэдээллийн олон сайт, фэйсбүүк групп, телевиз, радио зэрэг олон хэрэгслүүд байгааг бүгд л ямар нэгэн байдлаар ажил олоход нь дэмжлэг үзүүлж байна. Жишээлбэл, http://brigad.mn/brigad/431 гэсэн сайт (Зураг 23).



Зураг 23. Brigad.mn сайт

Дээрх сайтанд 12 төрлийн 294 бригадууд сайн дурааараа бүртгүүлсэн байгаа бөгөөд үүгээр дамжуулан ажлын захиалгаа олдог байна. Эдгээр бригадуудын мэдээллээр мэдээллийн баазаа өргөтгөх бүрэн боломжтой юм (Хүснэгт 6).

Хүснэгт 4. http://brigad.mn/ сайтанд бүртгэлтэй бригадуудын статистик үзүүлэлт

№	Бригадын төрөл	Бригадын тоо	Гишүүдийн тоо	Нэг бригадын гишүүдийн тоо /дунджаар/
1	Өрлөгийн бригад	32	218	7
2	Мужааны бригад	32	213	7
3	Дотоод Заслын бригад	69	126	2
4	Цахилгааны бригад	24	72	3
5	Сантехникийн бригад	18	77	4
6	Арматурын бригад	16	127	8
7	Каркас угсралтын бригад	46	340	7
8	Гадна Фасадны бригад	17	62	4
9	Дээврийн бригад	6	20	3
10	Шаврын бригад	12	20	2
11	Чулуу плитаны бригад	14	35	3
12	Гагнуурын бригад	8	19	2
	Нийт	294	1329	4

Энэ сайт итгэмжлэгдсэн хэмээх зэрэглэл тогтоохыг хичээсэн боловч хэрэглээгээ төдийлөн нэмэгдүүлж чадаагүй, эсвэл бригадууд тогтвортойгоор өөрсдийгөө зарлан сурталчлан чадвар хомс байгаагаас үүдэлтэй зөвхөн 1 л бригад итгэмжлэгдсэн зэрэглэлтэй байна.



Зураг 24. Бригадуудад шаардлагатай байгаа сургалтын төрөл

Судалгаанд хамрагдсан бригадуудаас сургалтын ямар хэрэгцээ байгааг үнэлэх зорилгоор мэргэжлийн, бизнесийн, эрх зүйн, технологийн, хөдөлмөр, аюулгүй байдал, эрүүл ахуйн болон бусад чиглэл гэсэн асуулт асуусан (Зураг 24). Үүнд 28.3 % нь мэргэжлийн, 21% нь ХАБЭ, 12.7% нь бизнесийн, 11% нь эрх зүйн болон технологийн сургалтуудын хэрэгцээ шаардлагатай байна хэмээн илэрхийлжээ.

Бригадуудын 66.4% нь мэргэжлийн үнэмлэх сертификаттай гишүүнтэй бөгөөд тэд ихэвчлэн бригадын үндсэн гишүүн эсвэл сантехник, цахилгаан гэх мэт нарийн мэргэжлийн сертификаттай байна.

Судалгаанд хамрагдсан бригадууд ихэвчлэн өөрсдийн багц багаж хэрэгсэлтэй (үйл ажиллагааны чиглэл бүрээрээ) байгаа бөгөөд үнийн хувьд 300 мян-10 сая орчим төгрөгийн багаж хэрэгслийг ашигладаг байна. Үүнээс дээш үнэтэй багаж хэрэгслийг захиалагч тал өөрөө хангаж ажилладаг байна. Тодруулбал, судалгаанд оролцогчдын 71% нь мэргэжлийн тодорхой багаж, хэрэгсэлтэй бөгөөд энэ нь бригадын зах зээлд ажил олж авахад зайлшгүй нөлөөлөх хүчин зүйл юм. Иймд тодорхой чиглэлээр тогтмол үйл ажиллагаа явуулдаг бригадууд ерөнхийдөө багажтай байх хандлагатай байна.

Мөн бригадуудын 70.5% сүүлийн 3 жилд үйл ажиллагаа идэвхтэй явуулж байгаа бөгөөд ажлын хэмжээ нь 2 сая төгрөгийн үнэлгээтэй 40 мкв хэмжээтэй дотоод заслын ажлаас 1.2 тэрбум төгрөгийн үнэлгээтэй 15000 мкв. талбай бүхий объектын угсралт хүртэл маш өргөн хүрээтэй өндөр хүчин чадал бүхий ажлуудыг хийж гүйцэтгэжээ.

Бригадад байгаа эмэгтэй гишүүдийг авч ажиллуулдаг дараах шалтгаан байна. Үүнд:

1. Гэр бүлийн гишүүдийн аль нэг нь бригадын ахлагч байгаа ба нэг нь харилцан дэм болж ажиллах зорилгоор

2. Арматур зангидах зорилгоор

3. Эсгүүр, нарийн мэргэжлийн зарим ажилд

4. Заслын, шаврын, будгийн, замаск хийх, цэвэрлэгээний болон тогоочийн үүргийг гүйцэтгэх зорилгоор бригадуудад эмэгтэйчүүд ажиллаж байна.

Оролцогчид эмэгтэйчүүдийн ажлын талаар дараах дүгнэлтийг өгч байна. Үүнд эмэгтэйчүүд ажилдаа хариуцлагатай, нямбай, өөрийн эзэмшсэн мэргэжилдээ чадварлаг, тууштай, ажил тасалдаггүй, нарийн ажил сайн хийдэг, цэвэрч, цаг баримталдаг гэж үзсэн байна.

Бригадуудын ахлагч нарт танай бригадад шаардлагатай технологийн сургалтыг үнэ төлбөргүй явуулаад “Гэр хорооллын байшинг дулаалах“ ажлын санал тавьбал тухайн ажлыг гүйцэтгэх эсэх талаар нь санал авахад судалгаанд оролцогчдын 58.8% нь оролцох сонирхолтой, 15.2 % нь оролцохгүй, 26 % нь оролцох эсэхээ мэдэхгүй гэсэн хариулт өгчээ (Зураг 25).



Зураг 25. Бригадуудын ахлагч нарын төслийн талаарх санал

Мөн 59% нь баг бүрдүүлж тус төсөлд ажиллах боломжтой гэсэн бөгөөд баг хамт олноо хуучин ажиллаж байсан нөхдөөс, туршлагатай, ур чадвартай, мэргэжлийн дадлага туршлагатай, идэвхтэй хөдөлмөрч, олон жил эсвэл олон ажил дээр хамтарч ажиллаж байсан туршлага дээр үндэслэн сонгон авахаа илэрхийлж байна.

Эцэст нь бригадын тогтвортой байдлыг тогтвортой гэрээгээр, байнгын ажлаар хангах замаар, тогтмол хангалттай цалин хөлсөөр, санхүүгээ тогтвортой байлгаснаар хангах боломжтой гэсэн байна.

БҮЛЭГ 3. СУДАЛГААНД ХАМРАГДСАН БАРИЛГЫН САЛБАРТ АЖИЛЛАХ СОНИРХОЛ БҮХИЙ ИРГЭДИЙН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Барилгын салбарт ажиллах сонирхол бүхий иргэдийн судалгааг барилга дээр ажиллаж буй, барилгын материалыг хайж буй буюу барилгын үйл ажиллагаатай холбоотой 100 айл зах, Гурвалжингийн гүүрний орчмын захууд, Хермес худалдааны төв зэрэг төвлөрсөн захууд орчмоор ажиллаж буй барилгатай холбоотой асуудлаар эрэл хайгуул хийж буй иргэдээс авсан болно.

Мөн Зар мэдээ сонин, facebook, зарын бусад сайтуудад зар өгч сонирхсон этгээдэд утсаар мэдээллийг өгөх, улмаар өөрийн биеэр ирж анкет бөглөх замаар судалгаанд хамруулаа.

Барилгын салбарт ажиллах сонирхол бүхий иргэдийн судалгаанд нийт 714 иргэнийг хамруулж чадсан бөгөөд 665 иргэний мэдээлэлд өгөгдлийн боловсруулалт хийж ажиллалаа. Бусад нь шаардлага хангаагүй болно.

Судалгаанд барилгын салбарт ажилладаг 665 иргэн оролцсоноос 521 (78.3%) нь эрэгтэйчүүд, 144 (22.7%) нь эмэгтэйчүүд үүнээс төслийн хүрээнд Гэр хорооллын байшин дулаалах сонирхолтой иргэн 412 буюу 62% нь байгаагийн 331 (80.3%) нь эрэгтэй 81 (19.7%) нь эмэгтэй байна. Нийт оролцогчдын ерөнхий ажлын туршлага жигд боловч барилгын салбарт ажилласан байдлаараа ялгаатай үүнд 248 (42%) буюу дийлэнх нь 4 хүртэл жил болон 191 (32.3%) нь 5-9 жил тус салбарт ажилласан байна. Энэ нь тус салбар ойрын жилүүдэд сэргэсэн бөгөөд идэвхтэй хөгжиж байгаатай холбоотой. Насны ангиллаар үзвэл 40-55 насныхан (25%), 20-29 (58%) насныхан түлхүү оролцсон нь энэхүү салбарын онцлогийг илтгэж байна. Нийт оролцогчдын 379 (57 %) нь гэрлэсний дийлэнх нь 40-55 насныхан (35.4%) байгаа нь тэдгээрийг тогтвор суурьшилтай байх хандлагатайг харуулж байна, харин 20-24 насныхан гол төлөв гэрлээгүй (47.5%) эсвэл хамтран амьдрагчтай (41.2%) байна. Ам бүлийн хувьд ихэвчлэн 4-7 (59.6%) ам бүлтэй бөгөөд гэр (34.4%) эсвэл хашаа байшинд (35.5%) амьдарч байна. Ингэхдээ гол төлөв өөрийн эзэмшлийн (74.9%) сууцтай байна. Сүүлийн 3 жилд Улаанбаатар хотод ихэвчлэн (75%) ажил хийсэн иргэд оролцсон байна.

Судалгааг Улаанбаатар хотын төвийн 6 дүүргийн хэмжээнд зохион байгуулсан боловч Налайх, Багануур, Багахангай дүүрэг болон бусад хөдөө орон нутгийн харьяалалтай иргэд ажлын байрны онцлогоос хамаарч тус судалгаанд хамрагдсан. Судалгаанд хамрагдагсдын 83 хувь нь төвийн 6 дүүргээс, 17 хувь нь Налайх, Багануур, Багахангай дүүрэг болон бусад хөдөө орон нутагт барилгын салбарт ажиллаж буй иргэд байна. Харъяаллаар нь авч үзвэл 158 нь буюу 23.8% нь Баянзүрх дүүрэгт, 149 (22.4%) хувь нь Сонгинохайрхан дүүрэгт, 72 (10.8 %) нь Хан–Уул дүүргүүдэд ажиллаж байна (Зураг 26).

Зорилтот 6 дүүргээс судалгаанд хамрагдсан иргэд нь нийт судалгаанд оролцогчдын 81 хувийг эзэлж байна.



Зураг 26. Судалгаанд хамрагдсан иргэдийн харьяалал

Судалгаанд барилгын салбарт ажилладаг 665 иргэн оролцсоноос 521 (78.4%) нь эрэгтэйчүүд, 144 (21.6%) нь эмэгтэйчүүд байна(Зураг 27).



Зураг 27. Судалгаанд оролцсон иргэдийн хүйсийн харьцаа

Дээрх 665 иргэнээс төслийн хүрээнд Гэр хорооллын байшин дулаалах сонирхолтой иргэн 412 буюу 62%-аас 331 (80.3%) нь эрэгтэй, 81 (19.7%) нь эмэгтэй байна (Зураг 28).



Зураг 28. Төсөлд хамрагдах сонирхолтой иргэдийн хүйсийн харьцаа

Судалгааны оролцогчид насны хувьд харьцангуй жигд тархалттай байгаа ач холбогдолтой, үнэмшлийн зэрэглэл өндөртэй буюу төлөөлөх чадвартай байгааг харуулж байна (Зураг 28).

Зураг 29. Судалгаанд оролцогчдын насны ангилал

Насны бүлгээр авч үзвэл 169 нь буюу 25 % нь 40 – 55 насныхан, 131 (19.7%) нь 25-29 насныхан, 127 (19.1%) нь 20–24 насныхан, 112 (16.8%) нь 30–34 насныхан, 95 (14.3%) нь 35-39 насныхан, 56 – с дээш насныхан 31 (4.7%) судалгаанд хамрагджээ.



Зураг 30. Судалгааны оролцогчдын ам бүлийн тоо

Ихэнх оролцогчид олон ам бүлтэй байгаа нь судалгаанаас ажиглагдсан. Үүнд 4-7 ам бүлтэй (60 %) , 3 хүртэл ам бүлтэй нь 23.5 %, 8 – аас дээш ам бүлтэй иргэн 16.7 % оролцсон байна (Зураг 30).



Зураг 31. Амьдарч байгаа орон сууцны төрөл

Амьдарч байгаа орон сууцны төрлөөр нь авч үзвэл 226 нь буюу 34 % нь гэрт, 204 (30.7 %) нь байшинд, 177 (26.6 %) нь орон сууцанд, 29 (4.4 %) хувь нь нийтийн байранд, 23 (3.5 %) нь тохилог сууцанд амьдардаг байна (Зураг 31).



Зураг 32. Сууцны эзэмшлийн хэлбэр

Судалгаанд оролцогчдыг сууцны эзэмшлийн төрлийг өөрийн, бусдынх түрээстэй, бусдынх түрээсгүй гэсэн ангиллаар авч үзэхэд 469 нь буюу 70.5% нь өөрийн эзэмшлийн сууцандаа амьдардаг, 124 нь буюу 18.6% нь түрээсийн сууцанд, 72 буюу 10.8% бусдынх боловч түрээсэнд мөнгө төлдөггүй амьдардаг байна. Нийт судалгаанд

оролцогчдын 29.4 хувь нь бусдын аль нэг төрлийн орон сууцанд амьдардаг байна (Зураг 32-33).



Зураг 33. Судалгаанд оролцогчдын орон сууцны эзэмшлийн хэлбэр



Зураг 34. Судалгаанд оролцогчдын гэр бүлийн байдал

Гэр бүлийн байдлын хувьд 379 нь буюу (57%) нь гэрлэсэн, 153 (23%) нь огт гэр бүл болоогүй, 70 (10.5%) нь хамтран амьдардаг, 63 (9.5%) нь тусдаа болон салсан, бэлэвсэн иргэд хамрагдсан байна (Зураг 34, Хүснэгт 7).

Хүснэгт 5. Ам бүлийн тоо, насны ангиллаар

		Насны ангилал						Дүн
		20-24	25-29	30-34	35-39	40-55	56-аас дээш	
Гэрлэлтийн байдал	Огт гэр бүл болоогүй	68	42	21	13	6	2	152
	Гэрлэсэн	21	60	75	69	133	24	382
	Хамт амьдардаг	24	21	5	5	13	1	69
	Тусдаа амьдардаг	7	2	4	2	4	1	20
	Цуцалсан	4	5	5	4	8	2	28
	Бэлэвсэн	2	2	2	2	5	1	14
Нийт		126	132	112	95	169	31	665

Судалгаанд ихэвчлэн гэр бүлтэй (62%) 30-55 насныхан оролцсон нь оролцогчдын тогтвор суурьшилтай байх хандлагыг илэрхийлж байна .



Зураг 35. Судалгаанд оролцогчдын боловсролын түвшин

Боловсролын түвшингээр нь харвал судалгаанд оролцогчдын 421 буюу 63.3 хувь нь бүрэн дунд, 178 буюу 26.8 хувь нь дээд, 9.9 хувь буюу 66 нь техникийн болон мэргэжлийн, бага боловсролтой иргэд судалгаанд хамрагджээ (Зураг 35).



Зураг 36. Өрхийн дундаж орлого

Өрхийн дундаж орлогод хамгийн өндөр хувь эзэлж байгаа нь 229 (34.4%) нь 501-800 мянган төгрөгийн сарын цалинтай, 184 (27.7%) нь 801-1200 мянган төгрөг, 105 (15.8 %) нь 186- 500 мянган төгрөгийн, 70 (10.5%) нь 1201 – 1500 мянган төгрөг, харин цөөнх буюу 47 (7.1 %) нь 1501 мянган төгрөгөөс дээш орлоготой байгаа бол үлдэх 4.5 хувь нь 185 мянгаас доош төгрөгийн орлоготой байна (Зураг 36).

Өрхийн орлогын хэмжээ нас, хүйс, ам бүлийн тооноос үл хамаарах бөгөөд харин боловсролын түвшингээс хамаарч байгаа нь ажиглагдаж байна. Оролцогчдын 201 (32.4%) нь 501000-800000 төгрөгийн цалинтай ба үүнд бүрэн дунд боловсролтой иргэд нь 144 (23.2%) байна (Хүснэгт 8).

Хүснэгт 6. Өрхийн орлого, боловсролын түвшингээр

		Өрхийн дундаж орлого						Нийт
		185,0 мян хүртэл	186,0-500,0 мян	501,0-800,0 мян	801,0-1200,0 мян	1201,0-1500,0 мян	1501,0 - аас дээш	
Боловсролын түвшин	Боловсролгүй	6	1	4	3	0	0	14
	Бага	1	3	4	3	1	0	12
	Суурь	0	0	6	5	2	0	13
	Бүрэн дунд	18	83	164	117	27	13	422
	Дээд	3	16	38	52	37	32	178
	Техникийн болон мэргэжлийн	2	2	13	4	3	2	26
Бүгд		30	105	229	184	70	47	665

Иргэдийн 67.7 хувь (450) нь жолооны үнэмлэхтэй, 32.3 хувь нь (215) нь жолооны үнэмлэхгүй иргэд байна. Харин судалгаанд 4 хүртэл жил ажилласан иргэд 27 хувь, 5-9 жил ажилласан иргэд 29 хувь, 10-14 жил ажилласан иргэд 23 хувь, 15-аас дээш жил ажилласан иргэд 21 хувь байна. Өөрөөр хэлбэл ажилласан жилийн байдал харьцангуй жигд тархалттай байна.

Харин үүнээс барилгын салбарт ажилласан жилээр нь тооцож үзвэл 42 хувь нь 4 хүртэл жил ажилласан иргэд хамрагдсан бол, 5-9 жил барилгын салбарт ажиллаж буй иргэд 32 хувь, 10-14 жил ажилласан иргэд 15 хувь, 15-аас дээш жил ажилласан иргэд 11 хувийг эзэлж байна. Өөрөөр хэлбэл судалгаанд хамрагдсан иргэд ямар нэг байдлаар барилгын салбарт ажиллаж буй иргэд хамрагдсан нь судалгааны зорилготой нийцэж байна гэсэн үг юм.

Судалгаанд оролцогчид сүүлийн 3 жилийн хугацаанд 477 буюу 75 хувь нь нийслэлд, 62 буюу 10 хувь нь аймагт, мөн 10 хувь нь суманд ажиллаж байсан бол үлдэх 20 буюу 3 хувь гадаадад мөн 15 буюу 2 хувь нь бусад газруудад ажиллаж байсан байна (Зураг 37).



Зураг 37. Судалгаанд оролцогчдын сүүлийн 3 жилийн хугацаанд ажиллаж байсан газар

Ажлын захиалгыг судалгаанд оролцогчдын 37.9 хувь нь өөрөө хайж олдог, 32.8 хувь нь танилаараа дамжуулж, 7.6 хувь нь вэб сайтнаас, 4.1 хувь нь хөдөлмөр зуучлалын байгууллагаар дамжуулдаг бол телевиз болон бусад эх сурвалжаас 10.7 хувь нь мэдээлэл авч ажил олдог байна (Зураг 38).



Зураг 38.Судалгаанд оролцогчдын ажил олж авдаг сувгууд

Судалгаанд оролцогчдын 65 хувь нь ажлаа сүүлийн гурван жилд солиогүй бол, 28 орчим хувь нь 1 – 3 удаа, 6 хувь нь 4 – с дээш удаа сольсон байна. Өөрөөр хэлбэл барилгын салбарын ажилд улирлын чанартай нөлөөлөл их, ихэнх ажлыг шаардлагатай үед нь бригадаар гүйцэтгээд дуусдаг болохыг судалгааны оролцогчид илэрхийлж байна (Зураг 39).



Зураг 39. Сүүлийн 3 жил ажлаа сольсон байдал

Ажилчдын 261 буюу 23 хувь нь цалин боломжийн, 245 буюу 22 хувь нь олон жил ажиллаж дассан, 243 буюу 21 хувь ажилдаа дур сонирхолтой, 169 буюу 15 хувь нь ажлын байр ховордсон, 160 буюу 14 хувь нь ажлын нөхцөл уур амьсгал сайн гэсэн бол

61 буюу 5 хувь нь урт хугацааны зээлтэй тул тус салбарт тогтвортой ажилладаг гэж хариулсан байна (Зураг 40).



Зураг 40. Ажлаа тогтвортой хийж байгаа шалтгаан

Харин 240 буюу 37 хувь нь улирлын чанартай, 140 буюу 21 хувь нь ажлын нөхцөл хүнд, 117 буюу 18 хувь нь цалин бага, 73 буюу 11 хувь нь шилжих хөдөлгөөн, 43 буюу 7 хувь нь мэргэжилгүй улмаас ажлаа сүүлийн 3 жилд 4 – с дээш удаа сольсон байна (Зураг 41).



Зураг 41. Ажлаа тогтворгүй хийж байгаа шалтгаан

Ажлын туршлагаар нь үзвэл 14.8 хувь нь шавар дотор засал, 13.0 хувь нь гадна фасад, 11.8 хувь нь хаалга цонх, шал суурилуулах ажил, мөн 11.8 хувь нь угсралт цутгалт, 11.6 хувь нь өрлөг, 10.5 хувь нь дээврийн ажил зэрэг ажлуудыг хийж байсан байна (Зураг 42).



Зураг 42. Барилгын салбарт хийж гүйцэтгэж байсан ажил

Барилгын салбарт ажиллаж байгаа судалгаанд хамрагдсан оролцогчдын 338 буюу 64.5 хувь нь хэн нэгний захиалгаар, хүсэлтээр барилгын ямар нэгэн ажил хийдэг гэж хариулсан бол 170 буюу 32.4 хувь нь үгүй гэж хариулжээ.

Эмэгтэйчүүдтэй хамтран ажиллахад дийлэнх хувь нь тэднийг ажилдаа хариуцлагатай, дотоод заслын ажлыг сайн гүйцэтгэдэг гэсэн бол сул тал нь барилгын салбар хүнд бөгөөд энэ салбарт мэргэшсэн эмэгтэйчүүд ховор бөгөөд жирэмсний амралтаа авдаг гэсэн хариулт өгсөн байна (Хүснэгт 9).

Хүснэгт 7. Эмэгтэйчүүдтэй ажиллах давуу болон сул тал

№	Давуу тал	Хувь	№	Сул тал	Хувь
1	**Хариуцлагатай**	46.5	1	Барилгын салбар хүнд	48
2	**Тогтвор суурьшилтай**	11.8	2	Барилгын салбарт мэргэшсэн цөөн	17.7
3	**Дотоод заслын ажлыг сайн гүйцэтгэдэг**	27.4	3	Жирэмсний амралтаа авч ажлаас хөндийрдөг	19
4	**Хямд ажиллах хүч**	6.8	4	Гомдол гаргадаг	9.2
5	**Түшигтэй**	7.6	5	Бусад	5.3

Ажил хийхэд чухал зүйл дээр судалгаанд оролцогчдын 409 буюу 31.7 хувь нь цалин хөлс, 276 буюу 21.4 хувь нь аюулгүй байдал, эрүүл мэнд, 205 буюу 15.9 % хувь нь урт хугацаанд тогтвортой ажиллах, 199 буюу 15.4 хувь нь баг хамт олон, 173 буюу 13.4 хувь нь өөрийн ур чадвар мэргэшил гэсэн хариултуудыг өгсөн байна (Зураг 431).



Зураг 43. Ажил хийхэд чухал нөхцөл

Барилгын дулаалгын чиглэлээр мэргэших сонирхолтой байдлыг тодруулахад судалгаанд оролцогчдын 62 хувь нь тийм, 19 хувь нь мэдэхгүй болон үгүй гэсэн хариултыг өгсөн байна (Зураг 44).



Зураг 44. Барилгын дулаалгын чиглэлээр мэргэших сонирхол

Барилгын дулаалгын чиглэлээр мэргэшүүлэх чиглэлийг тодруулахад 236 буюу 21.9 хувь нь цонхны дулаалга, шавар амалгаа, 238 буюу 22.1 хувь нь гадна фасад, 225 буюу 21 орчим хувь нь дээврийн дулаалга, 188 буюу 17.5 хувь нь мужаан, 121 буюу 11.2 хувь нь суурийн дулаалгын чиглэлээр мэргэшээд ажиллах сонирхолтой байгаа бол 68 буюу 6.3 хувь нь чадахгүй гэсэн хариулт өгсөн байна (Зураг 45).



Зураг 45. Дулаалгын чиглэлээр сурч цаашид хийх ажлын сонирхол

Барилгын дулаалгын ажлыг цаашид тогтмол хийх боломжийг тодруулахад судалгаанд оролцогчдын 48 хувь нь чадна, 22 хувь нь чадахгүй, 20 хувь ажлын хажуугаар хийнэ, 9 хувь нь тогтмол хийнэ гэсэн хариултуудыг өгсөн байна.



Зураг 46. Байшин дулаалах ажил цаашид тогтмол хийх хандлага

Багаа хэрхэн бүрдүүлдэг тал дээр 258 (33.0%) нь танилуудаасаа, бэлэн байгаа бригадуудтай хамтран орж ажиллана гэсэн нь 238 (30.5%) байна. Мөн 92 (11.8%) нь зөвхөн өөрөө, 71 (9.1%) нь эхнэр, нөхөр хүүхдээ ажиллуулана, 58 (7.4%) нь мэдээллийн хэрэгслээс багаа бүрдүүлнэ гэсэн бол 64 (8.2%) нь мэдэхгүй гэсэн хариулт өгсөн байна.

Судалгаанд оролцогчдын 339 буюу 51 хувь нь зээлгүй, 223 буюу 38.5 хувь нь зээлтэй байгаа бол үлдэх хувь 2.9 хувь нь зээлтэй эсэхээ үл мэддэг байна. Гэр бүлийн хэн нэг нь зээл авсан байж болзошгүй тул би сайн мэдэхгүй гэсэн санаа юм. Зээл авах шаардлага тулгарсан үед 143 буюу 29.4 хувь банкинд, 72 буюу 14.8 хувь нь ломбардад, 69 буюу 14.2 хувь нь ББСБ-дад ханддаг бол үлдсэн хувь нь ах дүү болон албан байгууллагаас мөнгө зээлдэг байна (Зураг 47).

Өөрөөр хэлбэл тогтмол орлоготой биш, улирлын чанартай, нийгмийн даатгалын шимтгэл төлдөггүй, орлогоо нотолж чаддаггүй зэрэг нь тухайн иргэдийг банкинд хандан зээл авах боломжийг төдийлөн хангадаггүй нь харагдаж байна.



Зураг 47. Зээл авах шаардлага тулгарсан үед ханддаг газар

134 оролцогч буюу 23.6 хувь нь зээлийн хүү өндөр, 85 буюу 15 хувь нь материал бүрдүүлэхэд хэцүү, 69 буюу 12.1 хувь нь өмнөх зээл дуусаагүй, 57 буюу 10 хувь нь барьцаа хөрөнгөгүй мөн олдоц ховор, шимтгэл өндөр, хугацаа их ордог зэрэг хүндрэлүүдийг дурьдсан байна (Зураг 48).



Зураг 48. Зээл авахад тохиолддог хүндрэлүүд

Судалгаанд оролцогчдын 56 хувь нь сургалтанд хамрагдаж байсан бөгөөд тэр дундаа ХАБ (40%) болон барилгын салбарын мэргэжлийн сургалт (40%), мөн хүнд машин механизмын (8%) сургалтуудад хамрагдаж байсан байна (Зураг 49).



Зураг 49. Судалгаанд оролцогчдын сургалтанд хамрагдаж байсан байдал

Оролцогчдын 70.4 хувьд (352) нь мэргэжил эзэмших, мэргэжлээ дээшлүүлэх хэрэгцээ шаардлага байдаг ажээ (Зураг 50).

Зураг 50. Шаардлагатай байгаа сургалтын хэрэгцээ

Сургалт явуулбал оролцогчдын 215 буюу 40 хувь нь барилгын салбарт чиглэсэн сургалт, 134 буюу 24.9 хувь нь өөрийн мэргэжлийн зэргээ ахиулахад чиглэсэн, 56 буюу 10.4 хувь нь удирдлагын чиглэлийн сургалт шаардлагатай байна гэсэн бол нярав, нягтлан, үйлчилгээний салбарын сургалт шаардлагатай гэсэн байна. Сургалтын хэрэгцээ нь оролцогчдын жилийн 4 улиралд тасралтгүй ажиллах сонирхол боломжтой уялдаж байгааг анхаарах шаардлагатай.

Судалгаанд оролцогчдын 164 буюу 20.5 хувь, 156 буюу 19.5 хувь, 77 буюу 9.6 хувь нь нэгээс гуравдугаар саруудад харьцангуй завтай сургалтанд хамрагдах боломжтой гэсэн байна (Хүснэгт 10).

Хүснэгт 8. Сургалтанд хамрагдах боломжтой саруд, хувиар

Сар	Саналын тоо	Хувь
1-р сар	**164**	**20.5%**
2-р сар	156	19.5%
3-р сар	77	9.6%
4-р сар	40	5.0%
5-р сар	26	3.3%
6-р сар	35	4.4%
7-р сар	31	3.9%
8-р сар	32	4.0%
9-р сар	24	3.0%
10-р сар	27	3.4%
11-р сар	58	7.3%
12-р сар	130	16.3%

Харин өдөр цаг нь ялгаагүй боломжтой гэж хариулсан байна. Зарим оролцогчид амралтын өдрүүдэд сургалт авахыг илүүд үзсэн байна (Хүснэгт 11).

Хүснэгт 9. Сургалт авах боломжтой өдөр

Гараг	Саналын тоо	Хувь
Даваа гараг	**86**	**13.8%**
Мягмар гараг	77	12.4%
Лхагва гараг	79	12.7%
Пүрэв гараг	75	12.1%
Баасан гараг	81	13.0%
Бямба гараг	111	17.8%
Ням гараг	113	18.2%

Хөдөөнөөс хот руу орж ирж ажиллахад 120 буюу 40 хувь нь орон байрны, 62 буюу 20.6 хувь нь санхүүгийн, 42 буюу 14 хувь танил талын зэрэг хүндрэлүүд дийлэнхдээ тохиолддог байна (Зураг 51).



Зураг 51. Хөдөөнөөс хотруу ирж ажиллахад тулгардаг бэрхшээл

Судалгаанд хамрагдсан иргэдийн 224 нь хөдөө орон нутгаас Улаанбаатар хотод шилжин ирсэн, мөн албан бусаар шилжиж ирээгүй боловч түр амьдарч буй иргэд хамрагджээ.

Хамгийн том хүндрэлийг орон байр, амьдрах сууцны хүндрэл байдаг хэмээн дурджээ.



Зураг 52. Шалгуур үзүүлэлт 1-ийг хангасан бригадуудын ерөнхий үзүүлэлт



Зураг 53. Шалгуур үзүүлэлт 2-ийг хангасан бригадуудын ерөнхий үзүүлэлт



Зураг 54. Шалгуур үзүүлэлт 2-ийг хангасан бригадуудын ерөнхий үзүүлэлт /үргэлжлэл/



Зураг 55. Барилгын салбарт ажиллах сонирхол бүхий иргэний 1-р шатны сонгон шалгаруулалт, нэгдүгээр шалгууураар



Зураг 56. Нэгдүгээр шатны сонгон шалгаруулалт, хоёрдугаар шалгуураар



Зураг 57. Нэгдүгээр шатны сонгон шалгаруулалт, гуравдугаар шалгууруар

Зураг 58. Нэгдүгээр шатны сонгон шалгаруулалт, гуравдугаар шалгуураар



Зураг 59. Нэгдүгээр шатны сонгон шалгаруулалт, дөрөвдүгээр шалгуураар



Зураг 60. Нэгдүгээр шатны сонгон шалгаруулалт, тавдугаар шалгууураар





Зураг 61. Нэгдүгээр шатны сонгон шалгаруулалт, долоодугаар шалгуураар



Зураг 62. Нэгдүгээр шатны сонгон шалгаруулалт, наймдугаар шалгуураар



Зураг 63. Нэгдүгээр шатны сонгон шалгаруулалт, есдүгээр шалгуураар



Зураг 64. Нэгдүгээр шатанд тэнцсэн иргэдийн үзүүлэлт, 10 дахь шалгуураар

БҮЛЭГ 6. МОНГОЛ УЛСАД ХЭРЭГЖСЭН ИЖИЛ ТӨСТЭЙ ТӨСЛИЙН СУРГАМЖ, ЖИШЭЭ

Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж байгаа “Улаанбаатар-Цэвэр агаар төсөл” (УБЦАТ)-ийн хүрээнд нэг гудамжны хэсэг айлуудын дулаан алдагдлыг бууруулах, нэг эх үүсвэр бүхий дулааны шугам сүлжээнд холбох ЗАГВАР ТӨСӨЛ[5]-ийг иргэдийн оролцоонд тулгуурлан 2017-2018 онуудад үе шаттайгаар хэрэгжүүлжээ. Энэхүү төслийн зорилго нь агаарын чанарыг сайжруулах 1 ба 2 дугаар бүсийн

i) Гэр хорооллын айл өрхүүдийн байшин-сууцны дулаан алдагдлыг бууруулахад техникийн болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх

ii) Дулаан сууцанд бага түлш хэрэглэснээр агаарт хаягдах бохирдлын хэмжээг бууруулж байгааг бодит жишээнүүд дээр харуулах

iii) Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулахад хувь хүн, айл өрхийн оролцоо чухал болохыг нийслэлчүүдэд ойлгуулахад оршиж байв.

“Дулаалга аян”-ыг дараах үе шат, алхамууд дээр тулгуурлан хэрэгжүүлэв (Зураг 70). Үүнд:

хэлэлцүүлэх, төлөвлөх, хэрэгжүүлэх, хянах, сурталчлах зэрэг бөгөөд төслийг удирдах нэгж, нийлүүлэгч, хяналтын инженер, борлуулалтын ажилтан, айл өрх гэсэн оролцогч талуудаас бүрдсэн байна.



Зураг 65. Дулаалгын аян төсөлд оролцогчдын үндсэн үүрэг

[5] http://www.usip.mn/blogs/53

Гол үр дүн: “Дулаалга аян” загвар төсөлд хамрагдсан айлууд нь халаалтын улиралд түүхий нүүрсний хэрэглээгээ 30-50 хүртэл хувиар бууруулж, өрхийн төсвөө хэмнэсэн нь судалгаагаар тогтоогдоод байна. Энэхүү аяныг хэрэгжүүлэхэд НЗДТГ, Дэлхийн банк, Төслийг удирдах хорооны гишүүд, ШУТИС-ийн харъяа “Барилгын эрчим хүч хэмнэлтийн төв”, Дулаалгын материал үйлдвэрлэгч-ханган нийлүүлэгч компаниуд, нийслэлийн төвийн 6 дүүрэг, гэр хорооллын 400 орчим айл өрх, Дүнжингарав болон Драгон дахь нэг цэгийн үйлчилгээний төв зэрэг байгууллага хамт олны хамтын ажиллагаанд төсөл амжилттай хэрэгжжээ. Төсөлд оролцогч айлууд нь дараах шат дамжлагаар дулаалга аяныг хэрэгжүүлсэн байна (Зураг 71).



Зураг 66. Дулаалга аяныг хэрэгжүүлэх алхамууд

Байшингаа дулаалах аянд нэгдэх хүсэлтэй айл, өрхүүдэд дараах шаардлагыг тавьж гэрээнд тусган өгсөн байна (Зураг 72).



Зураг 67. Дулаалгын аянаас айлд тавигдах шалгуур үзүүлэлт

ТУН –ийн хяналтын систем нь манай төслийг цаашид амжилттай хэрэгжүүлэхэд ашиглаж болохуйц байна. ТУН нь аяны гол оролцогчид болох айл өрх, хяналтын инженер, борлуулалтын төв, нийлүүлэгчдийн үйл ажиллагааг хооронд нь холбох зохион байгуулах, хянах ажлыг хийдэг (Зураг 73).

Хяналтыг 1) програмаар дамжуулах болон 2) газар дээр нь очиж хянах гэсэн 2 үндсэн хэлбэрээр явуулж байсан байна.

1) Вэбэд суурилсан програм (dulaalga.usip.mn/monitoring) –аар дамжуулан өдөр дутмын айл өрхийн гэрээ байгуулалт, төлбөр төлсөн эсэхийг хянаж, төлбөрийн нэгдсэн мэдээллийг MS Excel хэлбэрээр авч урьдчилан тооцоолол хийжээ. Хяналт, төлбөрийн дүнг програмаас авах боломжтой болсноор татаасын тооцоог гаргаж, айл өрхийн хамрагдалтыг тандах боломжтой болсон.
2) Газар дээр нь очиж хянах ажлын хүрээнд дулаалга хийж байгаа айл өрхүүдийн явцын хяналтыг хийж, санал хүсэлтийг авч ажилласан.



Зураг 68. Дулаалгын аяны ТУН-ийн хяналтын программын хэсэг

Дулаалгын бригадыг сонгон шалгаруулахдаа гэр хорооллын нэг гудамжны 10 гаруй айлын байшингийн гадна дулаалгын ажлыг гүйцэтгэх чадвартай дулаалгын бригадыг сонгон авсан ба дараах шаардлагуудыг хангасан бол гэрээ байгуулан байгуулан ажилласан байна.

Дулаалгын бригадад тавигдах шаардлага:

- Барилгын гадна фасадны ажлыг бие дааж гүйцэтгэсэн, эсвэл туслан гүйцэтгэгчээр ажилласан туршлагатай болохоо харуулах

- Бүх төрлийн хөөсөнцөр /EPS, XPS/ болон эрдэс хөвөн дулаалгын материалуудыг угсрах, суурилуулах мэдлэг, туршлага бүхий хамт олонтой байх
- Гэр хорооллын нөхцөлд ажиллах боломжтой, харилцааны соёл, хувийн зохион байгуулалт сайтай байх
- Дулаалгын ажил гүйцэтгэхэд шаардагдах багаж хэрэгслээр бүрэн хангагдсан байх
- Хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдлаа ханган ажиллах мэдлэг, чадвартай байх

Дулаалгын бригад нь загвар төсөлд хамрагдсан айлуудын хашаанд хүргэгдсэн дулаалгын бэлэн материалаар гадна фасад, адар, суурийн дулаалгыг хийх ба төслийн болон мэргэжлийн байгууллагаас технологийн заавар зөвлөмж, угсралтын гарын авлагыг өгч, хамтран ажиллажээ.

Шалгаруулалтад оролцох хүсэлтэй бригад нь дээрхи шалгуур үзүүлэлтийг хангасан болохоо нотолсон мэдээлэл (өмнө нь гүйцэтгэж байсан ажлын фото зураг, ажил гүйцэтгэх гэрээ, ажилтнуудын мэргэжлийн үнэмлэх, дипломын хуулбар, тодорхойлолт)-ээ бэлтгэн, өргөдөл, санхүүгийн санал (нэгж талбайг дулаалах ажлын хөлс) - ын хамт мэдээллээ илгээн шалгаруулалтанд оролцсон байна.

Доорх зурагт үзүүлснээр байшинг дулаалах үйл ажиллагаа явагдсан байна (Зураг 74).



Зураг 69. Өрхийн байшинг дулаалах процесс

Энэ аяны эхний шатанд нийт 7 (Эко ноос ХХК, Монгол базалт ХХК, Росторг ХХК, МНТ Прожект,Эбмат ХХК, Гүрэн өргөө ХХК, Пирамид Индастри ХХК) нийлүүлэгчийн 11 бүтээгдэхүүн хэрэглэгдсэн бол 2 дахь шатанд нийт 7 нийлүүлэгчийн (Эко ноос ХХК, Монгол Базалт ХХК, Росторг ХХК, MNT Project ХХК, Гүрэн өргөө ХХК, Пирамид Индастри ХХК, Дэлгэр констракшн ХХК) 19 төрлийн дулаалгын материалыг ашигласан байна (Зураг 75).

Ханган нийлүүлэгч:	ГҮРЭН ӨРГӨӨ ХХК	
Дулаалгын материалын төрөл:	Чулуут өнгөлгөөтэй (EPS) хөөсөнцөр хавтан	Металл сайдингтай байгалийн эрдэст хөвөн дулаалга
Зузаан:	15 см	15 см
Зориулалт:	Гадна ханын дулаалга	Гадна ханын дулаалга
Нэг м² үнэ /НӨАТ орсон/:	41,250.00₮	59,510.00₮

Ханган нийлүүлэгч:	ЭКОНООС ХХК		
Дулаалгын материалын төрөл:	Хонины ноосон дулаалга, хуванцар сайдингтай	Хонины ноосон дулаалга, төмөр сайдингтай	Хонины ноосон дулаалга, уур ус тусгаарлагчийн хамт
Зузаан:	15 см	15 см	20 см
Зориулалт:	Гадна ханын дулаалга	Гадна ханын дулаалга	Адрын дулаалга
Нэг м² үнэ /НӨАТ орсон/:	49,000.00₮	57,000.00₮	36,000.00₮

Ханган нийлүүлэгч:	МОНГОЛ БАЗАЛЬТ	
Дулаалгын материалын төрөл:	Хуванцар сайдингтай чулуун хөвөн дулаалга	Чулуун хөвөн, уур ус тусгаарлагчийн хамт
Зузаан:	15 см	20 см
Зориулалт:	Гадна ханын дулаалга	Адрын дулаалга
Нэг м² үнэ /НӨАТ орсон/:	67,925.00₮	37,400.00₮

Зураг 70. Дулаалгын аянд ашиглагдсан дулаалгын материалууд



Зураг 71. Дулаалгын аянд оролцогч өрхийн ханын дулаалгын материалын сонголт

Аяны эхний шатанд айл өрхүүдийн гадна ханын материалын сонголтын хувьд хөөсөнцөр, эрдэс хөвөн төрлийн материалын харьцаа 53% : 47% буюу бараг тэнцүү байсан бол аяны хоёр дахь шатанд айл өрхүүд эрдэс хөвөн төрлийн материалыг өмнөх жилээс 15%-иар илүү их сонгогдох болсон (Зураг 76). Энэ нь эрдэс хөвөн төрлийн материалыг дагаж ирэх сайдингийн өнгө үзэмж, чанар зэргээс шалтгаалсан байна.

Дулаалгын аяны төслөөс шаардлагатай мэдээлэл, үе шат, анхаарах зүйлс зэргийг авч тайланд тусгалаа.

Харин энэ төслийн бригадуудтай ажилласан туршлагын талаар мэдээлэл хомс байсан хэдий ч тухайн төслийг гүйцэтгэсэн Росторг ХХК-ны дулаалгын бригад манай төсөлд ажиллахаар сонгогдсон болно.

ДҮГНЭЛТ, САНАЛ ЗӨВЛӨМЖ

Судалгааны ажлын хүрээнд явуулсан судалгаа, боловсруулалтаар дараах гол үр дүн, дүгнэлтүүдэд хүрсэн болно.

Бригад буюу БЖДҮЭ-ийн үйл ажиллагааг сайжруулах хүрээнд:

Нийт дулаан алдагдлын 25 хувь нь цонхоор, 25 хувь нь ханаар, 35 хувь нь тааз буюу хучилтаар, 10 орчим хувь нь шалаар алддаг. Үүнээс гадна агаар нэвтрүүлэлтийн хийц, хаших бүтээцүүдийн уулзвар хэсгүүдийг дулаалах, нүх сүвээр дамжуулан дулаанаа алдах тохиолдлууд ч бий. Ийм учраас дулаалгын бригад нь эдгээр хийц, хэсгийг дулаалах чадавхи бүхий байх ёстой.

Харин өнөөдөр барилгын салбарт үйл ажиллагаа явуулж буй өрлөгийн, мужааны, дотоод заслын, цахилгааны, сантехникийн, гагнуурын, шаврын, карказ угсралтын, гадна фасадны, арматурын, дээврийн, чулуу плитаны зэрэг 12 төрлийн бригадууд үйл ажиллагаа явуулж байна. Харин дулаалгын бригад нь дээрх аль нэг чиглэлээр дагнасан биш, холимог шинж чанартай, байшингийн хийцийг дахин дулаалах чадавхитай байх шаардлагатай байна. Иймд судалгаанд хамрагдсан бригадууд нь байшин дулаалах эрэлт хэрэгцээ байгаа учраас энэ чиглэлээр суралцаж мэргэших сонирхолтой байна.

Судалгааны явцад бригадууд нь хөрөнгө оруулагч, захиалагч, гүйцэтгэгч байгууллагатай гэрээтэй гэрээгүй ажилладаг хэдий ч ажил дуусаны дараа хөдөлмөрийн хөлсөө цаг хугацаанд нь эсвэл бүр авч чадахгүй хохирох нь элбэг байна. Нийт судалгаанд оролцогчдын 89 хувь нь сүүлийн 3 жилийн хугацаанд ажлынхаа хөлсийг авч чадаагүй 3 хүртэл тохиолдол байна гэж илэрхийлжээ. Энэ нь нэг талаас бригадуудын эрх зүйн чадамж сул, нөгөө талаас захиалагчтайгаа ажлын чанар үр дүнг өөрсдийн чадвар чадамжинд суурилан зөв хүлээлт бүхий үр дүнг үзүүлж чадахгүй байгаатай холбоотой юм.

Түүнчлэн бригадууд татвар, даатгал төлдөггүй нь энэ судалгаанаас харагдаж байна. Өнөөдөр барилгын салбарын зах зээл дээр барилгын төрөл бүрийн ажлыг гүйцэтгэхдээ гадаад иргэний, компанийн, бригадын, хувь хүний гэсэн 4 төрлийн үнэ тариф мөрдөж байна. Үүний ялгаа зааг нь тухайн ажлын гүйцэтгэлийн чанар стандартаас гадна, татвар төлөх эсэхтэй ч холбоотой юм.

Барилгын компаниуд бригадаар ажлаа гүйцэтгүүлэх нь тэдэнд олон талаар ашигтай. Нэгдүгээрт, цалин хөлсний үнэлгээг багаар тохирч болно. Түүн дээр ажлын чанар, гүйцэтгэл тааруу гэсэн “шалтаг” гаргаж, хөлс мөнгийг нь дутуу хагас өгчих боломжтой. Хоёрт, тэдний өмнөөс хариуцлага хүлээх шаардлагагүй. Хэзээ ч, юугаар ч нөхөж баршгүй хүний ам насны асуудал юм. Гуравт, бригадад хамаарах ажилчдын элдэв даатгал, татвар, хөдөлмөр хамгааллын хэрэгсэл, хувцас зэрэгт мөнгө зарахгүй.

Бригадуудын үндсэн гишүүдийн тоо ихэвчлэн 3-6 хүн байх бөгөөд туслах гишүүнийг шаардлагатай үед нэмэх замаар бригад бүрдүүлж ажиллаж байна. Бригадууд 3-12 сард илүү ачаалалтай ажилладаг бол судалгаанд оролцогчдын 23 хувь нь жилийн дөрвөн улиралд үйл ажиллагаа явуулдаг байна.

Судалгаанд хамрагдсан бригадуудын 70 хувь нь жилийн 30 сая хүртэл төгрөгийн орлоготой ажилладаг байна. Энэ нь бид судалгаандаа бичил, жижиг гүйцэтгэгч нарыг тодорхойлох төслийн зорилготой нягт холбоотой юм. Өөрөөр хэлбэл томоохон гүйцэтгэгч нараас зайлсхийх, тэдгээрт гэрээгээр ажиллаж буй бригадуудыг оролцуулах зорилго тавьсантай ч холбоотой юм.

Харин бригадуудын олж буй орлого нь ХХК, барилгын зөвшөөрөлтэй ХХК, зөвшөөрөлгүй бригад уу гэдэг статусаас хамаарахгүй байна. Мөн бригадуудын орлого түүний гишүүдийн тоо, их бага байхаас ч хамаарахгүй байна. Энэ нь тэдгээрийн танил тал, өмнөх захиалагчаасаа ажлаа олж гүйцэтгэдэгтэй холбоотой юм.

Бригадын гишүүдийн 48 хувь нь хөдөө орон нутгийн иргэд байна. Бригадын гишүүдийн нийгмийн байдлыг судалж үзвэл 37 хувь нь гэрт, 38 хувь нь гэр хорооллын байшинд амьдардаг байна.

Мөн эдгээр бригадууд санхүүгийн, хүний нөөцийн хомсдол, найдвартай гэрээгээр ажиллах зэрэг асуудлыг тулгамдаж буй хамгийн гол бэрхшээл хэмээн тодорхойлсон байна. Ийм бригадуудын нийгмийн асуудал, тэдгээрийн сургах хөгжүүлэх асуудал, эрх зүйн мэдлэг чадвартай болгох аливаа ажлаа чанар стандартыг баримталж ажиллах, бизнесийн зарчмаар хийж гүйцэтгэх, гүйцэтгүүлж сурах хандлага ихээхэн чухал юм.

2018 оноос ажлын үнэлэмж өссөн бөгөөд хамгийн багадаа өдрийн 50 мянган төгрөг болсон байна. Гэтэл барилгын салбарт тогтвортой боловсон хүчин бүрэлдэж чадахгүй нь энэ салбарын улирлын шинж чанартай холбоотой.

Энэ мэтээр өгүүлээд байвал бригадуудад тулгарч буй хүндрэл, бэрхшээл, тэднийг тойрсон хууль бус явдал байгаа тул тэднийг анхаарч, авч хэлэлцэж, цэгцлэх шаардлагатай.

Бригадууд байгууллагад харьяалагдана гэдэг санхүүгийн бичиг цаас нь эмх цэгцтэй болж, хуулийн дагуу ажилладаг болохоос эхлэн тэдний эрүүл ахуй, хөдөлмөр, аюулгүй байдалд олон эерэг үр дүн, дэвшил гарна.

Харин эдгээр бригад, иргэнийг дулаалгын чиглэлээр мэргэшүүлэн сургах, гэрээ хийх зэрэг ажлуудыг яаралтай хийж гүйцэтгэх хэрэгтэй. Учир нь эдгээр сонгогдсон бригадууд барилгын ажил эхлэхтэй зэрэгцэн өөр ажилд орох магадлалтайг харгалзан дараа дараагийн ажлыг зөв уялдуулан тодорхойлох шаардлагатай. Тэгвэл тогтвортой, чадварлаг хүний нөөцтэй ажиллах боломж байна.